



Монголбанк

Санхүүгийн мэдээллийн алба

**СЭЖИГТЭЙ
ГҮЙЛГЭЭНИЙ
ТАЙЛАН
МЭДЭЭЛЭХ
ГАРЫН
АВЛАГА**

БАНК

2020 оны 5 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНДББ	Ази, Номхон далайн бүсийн байгууллага
МУТС	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ФАТФ	Мөнгө угаахтай тэмцэх олон улсын санхүүгийн арга хэмжээ авах байгууллага

АГУУЛГА

1	Танилцуулга	4
1.1	Өмнөх үг.....	4
1.2	Зорилго	4
1.3	Холбогдох журам, заавар.....	5
2	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх.....	5
2.1	Мөнгө угаах гэж юу вэ?	5
2.2	Мөнгө угаах 3 үе шат	6
2.3	Мөнгө угаахыг тодорхойлох нь	6
2.4	Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах.....	7
2.5	Террорист үйлдэл гэж юу вэ ?.....	7
2.6	Терроризмыг санхүүжүүлэхийг тодорхойлох нь.....	7
2.7	Зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ	7
2.8	МУТСТ олон улсын эрх зүйн зохицуулалт.....	8
2.9	Дотоодын эрх зүйн зохицуулалт	10
3	Сэжигтэй гүйлгээ	10
3.1	Сэжигтэй гүйлгээг илрүүлэх	11
3.2	Хэн мэдээлэх үүрэгтэй вэ?.....	12
3.3	Юуг мэдээлэх вэ?.....	13
3.4	Яаж мэдээлэх вэ?	14
4	Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах	14
5	Удирдлага болон ажилтнуудад зориулсан сургалт	15
5.1	Сургалтын агуулга.....	16
5.2	Сургалтын арга зүй болон давтамж	17
6	Сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд.....	17
6.1	Сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг гэж юу вэ?	17
7	Сэжигтэй гүйлгээний тухай нэмэлт мэдээлэл.....	18
7.1	МУТСТ тухай хуулийн дагуу нэмэлт мэдээлэл авах.....	18
8	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага.....	19
9	Мэдээллийн нууцлалыг задруулах	19
10	Хариуцлагаас чөлөөлөх	19
	Хавсралт 1. Сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд	21
1.	Түгээмэл шинж тэмдгүүд.....	21
1.1	Ерөнхий шинж тэмдгүүд.....	21
1.2.	Бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой шинж тэмдгүүд.....	25
2.	Салбарын онцлог шинж тэмдгүүд.....	37
	Хавсралт 2. Типологи	39

1 ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлагыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд болох БАНК-нд зориулан сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь мэдээлэл, чиглэл өгөх зорилгоор боловсруулав.

Банкны ажилтнууд сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг таних, илрүүлэх, мэдээлэхийн тулд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох, яагаад түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх шаардлагатай талаар ойлгож, сэжигтэй гүйлгээ, оролдлогыг таньж болох түгээмэл шинж тэмдгүүдийн талаар ерөнхий мэдлэгтэй байх шаардлагатай.

Иймд гарын авлагаар сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхэд хууль, журмаар тавигдах шаардлагуудын талаар мэдээлэл өгөхөөс гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой ерөнхий мэдээлэл, мэдлэг олгохыг зорилоо.

1.1 ӨМНӨХ ҮГ

Банк нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тогтоох, хуульд заасан гүйлгээнд тусгай хяналт тавих, сэжигтэй гүйлгээ, 20 сая төгрөгөөс дээш дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг СМА-нд мэдээлэх, хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг хэд хэдэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Энэхүү гарын авлага нь эдгээр үүргүүдээс зөвхөн сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхтэй холбоотой үүргийг таниулж, тайлбарлах болно.

Гарын авлагыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам, Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх тухай журам болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилгот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журамд тус тус нийцүүлэн боловсруулав.

1.2 ЗОРИЛГО

Гарын авлага нь дараах үндсэн гурван зорилготой. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой ерөнхий ойлголт өгөх;
- Сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ)-гаар юуг хэн, хэзээ, хэрхэн мэдээлэх вэ гэдгийг тайлбарлах замаар банкны ажилтнуудад хууль, журамд заасан сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг мэдээлэх үүргээ ойлгох, хэрэгжүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох сэжигтэй гүйлгээний ерөнхий болон бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог бүхий шинж тэмдгүүдийн талаар мэдээлэл өгч, банкны ажилтнуудад сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд туслах.

1.3 ХОЛБОГДОХ ЖУРАМ, ЗААВАР

Санхүүгийн мэдээллийн алба нь МУТСТ-тэй холбоотой батлагдсан хууль, журам, боловсруулж гаргасан гарын авлага, заавар зөвлөмжүүдийг өөрийн цахим хуудаст байршуулсан байгаа. Эдгээр баримт бичгүүдийг <https://fiu.mongolbank.mn/regulation.aspx> холбоосоор орж авч, ашиглаж болно.

Цахим хуудаст тавигдаагүй, зөвхөн мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хэрэгцээнд зориулан гаргасан баримт бичгүүдийг СМА-ны fiu@mongolbank.mn албан цахим шуудангийн хаяг руу э-мэйл бичиж эсхүл утсаар холбогдож авах боломжтой.

Түүнчлэн Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хороо нь өөрсдийн зохицуулалтад хамаарах мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан гаргасан гарын авлага, заавар зөвлөмж, мэдээ мэдээлэл болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг цахим хуудаснууддаа байршуулсан байдаг тул авч ашиглаарай.

2 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ

2.1 МӨНГӨ УГААХ ГЭЖ ЮУ ВЭ?

Гэмт хэрэг үйлдэж байгаа хувь хүн эсхүл бүлэг этгээдийн олонх нь ашиг хонжоо олох зорилгоор тухайн гэмт хэргийг үйлддэг. Мөнгө угаах гэдэг нь ийнхүү гэмт хэрэг үйлдэж олсон ашиг, орлогын хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хууль ёсоор олсон орлого мэт харагдуулах үйл явц юм. Энэ үйл явц нь гэмт хэрэгтнүүдэд гэмт хэргийн замаар олсон ашиг, орлогоо хууль бус эх үүсвэрийг нь мэдэгдэлгүй ашиглах, захиран зарцуулах боломж олгодог.¹

Хууль бусаар зэвсэг худалдаалах, хил давуулах болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын наймаа, биеэ үнэлэх зэрэг зохион байгуулалттай гэмт хэргүүдээс маш их хэмжээний орлого олдог. Түүнчлэн залилах, хулгайлах, хөрөнгө завших, авлигын гэмт хэрэг үйлдэх, үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж арилжаанд оролцох зэрэг бусад гэмт хэргүүдээс ч мөн их хэмжээний ашиг олдог бөгөөд гэмт хэрэгтнүүд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө асуудалгүй ашиглахын тулд мөнгө угаах замаар хууль ёсоор олсон мэт болгох арга зам хайна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж хөрөнгө, ашиг орлого олсон хувь хүн эсхүл бүлэг этгээд нь хууль, хяналтын байгууллагын анхаарлыг хийсэн хэрэг, хэрэг үйлдсэн этгээд рүү татахгүйгээр хууль бус хөрөнгө, орлогоо эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг санаархдаг. Ингэхдээ тэд хөрөнгө, ашиг орлогынхоо хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хэлбэр дүрсийг нь өөрчлөх, эсхүл анхаарал бага татахуйц газар луу шилжүүлдэг байна.

¹ <http://www.fatf-gafi.org/fag/moneylaundering/#d.en.11223>

Ийнхүү гэмт хэрэг үйлдэж олсон эсхүл хууль бус үйл ажиллагаанаас олсон хөрөнгө, ашиг орлогын хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах үйл явцыг мөнгө угаах гэж ойлгож болно. Дээр өгүүлсэнчлэн мөнгө угаах үйл ажиллагаа нь гэмт хэрэгтнүүдэд гэмт хэргээс олсон орлогоо чөлөөтэй ашиглаж, хуулийн хариуцлагаас зугатах боломжийг олгодог.

2.2 МӨНГӨ УГААХ 3 ҮЕ ШАТ

Дараах гурван үе шатны дагуу мөнгө угаадаг гэж үздэг. Үүнд:

1. **Байршуулах:** Хамгийн эхлээд гэмт этгээд нь хууль бусаар олсон хөрөнгө, мөнгөө санхүүгийн системд оруулах буюу байршуулна. Ингэхдээ их дүнтэй мөнгийг хуваан бага бага дүнгээр банкны дансанд хийх, замын чек гэх мэт төлбөрийн хэрэгслүүд худалдан авч, дараа нь өөр газар сольж мөнгийг нь дансанд хийх зэрэг арга замаар банк, санхүүгийн системд байршуулна.
2. **Нуун далдлах:** Дараагийн үе шатанд гарал үүслийг нь нуун далдлах, хууль бус эх үүсвэрээс нь аль болох холдуулах зорилгоор нэгэнт байршуулсан мөнгөө ийш тийш шилжүүлэх эсхүл хувиргана. Жишээ нь: хөрөнгө оруулалтын хэрэгсэл худалдан авах, зарах эсхүл хууль ёсны мэт харагдуулах зорилгоор гадаад худалдааны төлбөр тооцоо мэт утгатай гадаад шилжүүлгүүдийг мөнгө угаахтай тэмцэх хяналтын тогтолцоо муутай гадаад орнууд руу шилжүүлэх гэх мэт аргыг хэрэглэдэг.
3. **Буцаан төвлөрүүлэх:** Гэмт этгээд гэмт хэргээс олсон орлогоо дээр дурдсан хоёр шатанд амжилттай нэвтрүүлсний дараа гурав дахь буюу буцаан төвлөрүүлэх үе шатанд хөрөнгө, мөнгөө өөрийн болон хамаарал бүхий этгээдийн нэр дээр буцаан төвлөрүүлж авдаг бөгөөд хууль ёсны санхүүгийн системд дахин нэвтрүүлдэг. Нэгэнт гарал үүслийг нь тогтооход бэрх болсон эсхүл хууль ёсны мэт харагдах болсон хөрөнгө, мөнгөөрөө үл хөдлөх хөрөнгө эсхүл тансаг зэрэглэлийн хөрөнгө худалдан авах, эсхүл аль нэг бизнесд хөрөнгө оруулах зэргээр эзэмшиж, ашиглаж эхэлдэг аж.

Мөнгө угаах гэмт хэрэг нь ерөнхийдөө дээрх гурван үе шатаар дамждаг боловч заавал бүх үе шатыг хамрах шаардлагагүй тохиолдол ч байдаг байна.

2.3 МӨНГӨ УГААХЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т мөнгө угаахыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

“мөнгө угаах гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмисэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байриил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг”.

2.4 ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН МӨНГӨ УГААХ

Терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах аль ч тохиолдолд гэмт этгээдүүд хууль бус эх үүсвэрээс олсон хөрөнгө, мөнгөө аль болох хяналт, шалгалт багатай гэж үзсэн газраар дамжуулан шилжүүлэх сонирхолтой байдаг. Иймд банкны ажилтнууд мэдлэг, мэдээлэл сайтай байж, маш сайн хяналт тавих шаардлагатай бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, тавьдаг хяналтаа ижил түвшинд хийх шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үйлдэгдэж буй арга хэлбэр нь ижил төстэй боловч агуулгын хувьд энэ хоёр гэмт хэрэг ялгаатай.

Мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харагдуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэхэд террорист этгээд эсхүл байгууллага нь гэмт хэрэг үйлдэж мөнгө олохоос гадна хууль ёсны эх үүсвэрээр ч мөнгө босгодог. Түүхээс харвал терроризмыг санхүүжүүлэгчид нь албан бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, буяны байгууллагууд, бэлэн мөнгө зөөвөрлөгчдийг ашиглах гэх мэтээр гүйлгээг хууль ёсны мэт харагдуулах эсхүл нарийн төвөгтэй байдлаар хийх зэрэг тусгай аргуудыг ашиглаж байжээ.

2.5 ТЕРРОРИСТ ҮЙЛДЭЛ ГЭЖ ЮУ ВЭ ?

Террорист үйлдлийг “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх” тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т: дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

“террорист үйлдэл гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төр, олон улсын байгууллагаас хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардаж хүн амыг айдаст автуулах, хүнийг алах, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахыг;”.

2.6 ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т терроризмыг санхүүжүүлэхийг дараах байдлаар томъёолсон. Үүнд:

“терроризмыг санхүүжүүлэх гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;”.

2.7 ЗОРИЛТОТ САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн

зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам” нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан 1267 дугаар тогтоол болон түүний дагалдан гарсан тогтоолуудын дагуу НҮБ-аас жагсаалтад оруулсан, 1373 дугаар тогтоол болон түүний дагалдан гарсан тогтоолуудын дагуу Монгол Улсаас жагсаалтад оруулсан иргэн болон хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах эрх зүйн хүрээгээр хангадаг. (эдгээр нь бүхэлдээ санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ).

Санхүүгийн хориг арга хэмжээтэй холбоотой “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

i/ Хүн, хуулийн этгээд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан тогтоол, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Засгийн газраас баталсан тагнуулын байгууллагаас гаргасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдэгдэнэ.

ii/ Санхүү, бизнесийн этгээд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан тогтоол, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Засгийн газраас баталсан тагнуулын байгууллагаас гаргасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсхүл түүнийг төлөөлж буй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

iii/ Санхүү, бизнесийн этгээдээс энэ журмын i/ii-т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг зогсооно:

- Зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- Энэ журмын iii хэсгийн эхний 2-т заасан хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;
- НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолоор жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл.

2.8 МУТСТ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.8.1 ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

МУТСТ-тэй холбоотой хэд хэдэн олон улсын стандарт, баримт бичгүүд батлагдсан байдаг. Үүнд:

- Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус наймааны эсрэг гаргасан НҮБ-ын конвенц – Венийн конвенц – 1988 он;
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенц – Палермогийн конвенц – 2000 он;
- Авлигатай тэмцэх НҮБ-ын конвенц – 2005 он;
- ФАТФ-ын 40 Зөвлөмж (2012 он).

2.8.2 МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА - ФАТФ

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /The Financial Action Task Force FATF -ФАТФ/ нь 1989 онд гишүүн улс орнуудын сайд нарын байгуулсан олон улсын засгийн газар хоорондын байгууллага юм.

ФАТФ-ын зорилго нь олон улсын санхүүгийн системийн нэгдсэн байдалд аюул, занал учруулж байгаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон бусад холбогдох аюул заналхийлэлтэй тэмцэх хууль, эрх зүйн, зохицуулалтын болон үйл ажиллагааны стандартыг тогтоон хэрэгжүүлэхэд оршдог. Улс орнууд ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

Өөрөөр хэлбэл, ФАТФ-ын зөвлөмж нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхэд улс орны хэрэгжүүлэх шаардлагатай иж бүрэн, цогц арга хэмжээний ерөнхий хүрээг тодорхойлдог. Улс орнуудын хууль эрх зүй, засаг захиргаа, нийгэм, эдийн засгийн тогтолцоо болон санхүүгийн систем харилцан адилгүй тул дээр дурдсан аюул заналхийлэлтэй тэмцэх арга хэлбэр нь ч харилцан адилгүй юм. Иймд ФАТФ-ын зөвлөмж нь улс орнууд өөрийн онцлог нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх олон улсын стандартыг тогтоож өгсөн гэж ойлгож болно.

Монгол Улсын хувьд ФАТФ-ын бүс нутгийг хариуцсан салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (АНДББ)-ын гишүүн юм.

Жич: ФАТФ-ын 40 Зөвлөмжийг ФАТФ-ын цахим хуудсаас татаж авах боломжтой². Түүнчлэн СМА-наас ФАТФ-ын 40 Зөвлөмж буюу “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт”-ыг орчуулан цахим хуудсанд байршуулсан³.

² **FATF Recommendations 2012**

<http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf>

³ <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/Mongolian%20Translation%20FATF%20Recommendations%20mng.pdf>

2.9 ДОТООДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхдээ дараах хууль, журмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

- ✓ *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;*
- ✓ *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;*
- ✓ *Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;*
- ✓ *Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх тухай журам;*
- ✓ *Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам.*

3 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭ

Банк нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу дараах тохиолдолд сэжигтэй гүйлгээг СМА-нд мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

“Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол”.

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (СГТ)

Банк нь гүйлгээ эсхүл гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд тухайн мэдээллийг Сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

СМА-ны хувьд МҮЭ-ээс ирүүлж байгаа СГТ нь тухайн сэжиглэж буй гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагааг судлах, дүн шинжилгээ хийхэд мэдээллийн гол эх сурвалж болдог. Мөн СГТ нь сэжиглэж буй гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа нь нэг гүйлгээгээр хийгдсэн үү эсхүл хоорондоо холбоо бүхий хэд хэдэн гүйлгээгээр хийгдсэн үү гэх зэрэг тодорхой мэдээллүүдийг өгдөг.

СМА нь МҮЭ-ээс ирүүлсэн СГТ-ийн сэжиглэх үндэслэл, тайлбар болон бусад мэдээлэл, үзүүлэлтүүдэд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох ерөнхий эрсдэлийг үнэлэх бөгөөд эрсдэлийн оноо өндөр авснаас эхлэн тухайн гүйлгээ, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх хангалттай үндэслэлтэй эсэхэд дүн шинжилгээ хийдэг.

СГТ-нд дүн шинжилгээ хийх явцад СМА нь сэжигтэй гүйлгээнд холбогдсон этгээдийн талаарх нэмэлт мэдээллийг МҮЭ-ээс авах шаардлагатай байдаг. Эдгээр нэмэлт мэдээлэл нь тухайн сэжиглэх үндэслэл нь үнэхээр гэмт хэргийн шинжтэй байгаа эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Дүн шинжилгээний үр дүнд сэжиглэж буй гүйлгээ эсхүл гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой байж болзошгүй хангалттай үндэслэлтэй байна гэж үзвэл СМА нь хууль тогтоомжийн дагуу холбогдох хууль сахиулах байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

ЖИЧ: СГТ-г гүйлгээ хийгдсэн болон гүйлгээ хийхийг завдсан аль ч тохиолдолд мэдээлэх шаардлагатай бөгөөд сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тогтоосон босго гүйлгээний дүн гэж байхгүй.

3.1 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ ИЛРҮҮЛЭХ

Сэжигтэй гүйлгээ нь ихэвчлэн харилцагчийн өмнө хийж хэвшсэн гүйлгээ, үйл ажиллагаа, хувийн хэрэг эсхүл ажил, мэргэжил, бизнесийн үйл ажиллагаатай нь нийцээгүй гүйлгээ байдаг.

Ихэнх тохиолдолд банкны ажилтан нь харилцагч яг ямар гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа хийж байгааг мэдэх боломжгүй байх нь бий. Гэхдээ гүйлгээнүүд болон тэдгээрийг хийж байгаа арга хэлбэрийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой танигдсан типологи, арга хэлбэр, сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдэгтэй тохирч байгаа эсэхийг ажиглаж шалгаснаар аль нэг төрлийн гэмт хэргийн шинжтэй байгааг таамаглаж, сэжиглэж болно. Гүйлгээ нь дангаар нь авч үзэхэд сэжиг төрүүлэхгүй боловч цогцоор нь авч үзэхэд гэмт хэргийн шинжтэй байх боломжтой олон төрлийн хүчин зүйлстэй холбоотой байх нь ч бий.

Банкны ажилтнууд энэ гарын авлагын хавсралтад дурдсан сэжигтэй гүйлгээний жишээнүүд, сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдгийн жагсаалтаас ямар гүйлгээ сэжигтэй гүйлгээ байж болох талаар удирдамж, мэдээлэл авч болно. Гэхдээ эдгээр жишээ, жагсаалт нь зөвхөн мэдээлэл, чиглэл өгөх зорилгоор жагсаасан түгээмэл жишээнүүд бөгөөд сэжигтэй байж болзошгүй нөхцөл байдал нь эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй болохыг анхаарна уу. Эцсийн дүнд банкны ажилтнуудын мэдлэг, харилцагч болон түүний хийж буй гүйлгээг таньж мэдсэн, судалсан байдал л тухайн гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэх үндэслэлтэй эсэхийг тодорхойлохыг анхаарах нь зүйтэй.

3.1.1 СЭЖИГЛЭХ ҮНДЭСЛЭЛ

Банкны ажилтан нь харилцагчийн хийж байгаа / хийхийг завдаж буй гүйлгээтэй холбоотой үүсэж буй нөхцөл байдал (context) болон тухайн харилцагчийн талаарх банкны ажилтны мэдэж байгаа, олж авч чадах баримт мэдээлэл буюу харилцагчийн хувийн хэрэг, ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн түүх, өмнө хийж байсан гүйлгээний түүх зэрэг мэдээлэлд үндэслэн өөрийн итгэл үнэмшлийн дагуу сэжиглэх үндэслэлийг тогтоож, сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлагатай.

Банкны ажилтны авч хэрэгжүүлсэн харилцагчийг таньж мэдэх (ХТМ) ажиллагааг харилцагч, гүйлгээний талаарх мэдлэг, мэдрэмж, мэдээллээр баяжуулах ба энэ нь банкны ажилтанд сэжигтэй гүйлгээг таньж мэдэхэд чухал ач холбогдолтой.

СМА-нд мэдээлэгдэх СГТ бүр тухайн харилцагч, гүйлгээг яагаад сэжиглэж буй талаар тайлбарласан бөгөөд тодорхой үндэслэлтэй байх ёстой. Тухайлбал, тодорхой үндэслэлгүйгээр зөвхөн “өндөр дүнтэй гүйлгээ хийж байгаа” гэсэн шалтгаанаар сэжиглэх нь хангалтгүй юм. Харин харилцагчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн болон өмнө хийж хэвшсэн гүйлгээний талаарх мэдээлэлтэй нийцэхгүй байгаа өндөр дүнтэй гүйлгээг сэжигтэй гэж үзэх боломжтой. Энэ тохиолдолд тухайн гүйлгээг өмнөх гүйлгээний мэдээлэлтэй нь харьцуулах, мөн харилцагчийн ажил, бизнесийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд тухайн гүйлгээ хийгдэх нь хэвийн эсэхийг үнэлэх нь бодитой бөгөөд оновчтой сэжиглэх үндэслэлийг бий болгох боломжтой. Өөрөөр хэлбэл, банкны ажилтан нь харилцагч, гүйлгээтэй холбоотой СГТ-г бэлтгэж, мэдээлэхээс өмнө тухайн харилцагч, гүйлгээг шалгаж, өөрт байгаа болон цуглуулж чадах мэдээллийн хүрээнд анхан шатны дүн шинжилгээ хийж, сэжигтэй гэж үзэж болох шинж тэмдгүүдийг сайтар судлан сэжигтэй байж болзошгүй хангалттай үндэслэл байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх шаардлагатай. Ингэсэн тохиолдолд банкны ажилтан нь харилцагч, гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, эсхүл хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэгт холбоотой байж болзошгүй гэж үзэх тодорхой үндэслэлтэй болох юм.

Банкны мэдээлсэн СГТ дахь сэжиглэх тодорхой үндэслэл болон яагаад харилцагч, гүйлгээг сэжигтэй эсхүл сэжигтэй байж болзошгүй гэж үзсэн талаар бичсэн тайлбар нь СМА-нд тухайн СГТ-нг, сэжиглэх үндэслэлийг ойлгоход нь тус дөхөм болох юм. Цаашлаад СМА уг СГТ-нг дүн шинжилгээ хийхээр сонгох эсэх, өндөр эрсдэлтэй гүйлгээ мөн эсэх, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн дүн шинжилгээ хийх эсэх, хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах эсэхийг шийдэхэд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад суурь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход чухал ач холбогдолтой.

Сэжигтэй гүйлгээг банкны теллер, үйлчилгээний бусад ажилтан, комплаенсын мэргэжилтэн эсхүл данс хянах үйл явцаар илрүүлж болно. Банкны теллер эсхүл үйлчилгээний ажилтан харилцагч, гүйлгээг сэжигтэй байна гэж үзсэн тохиолдолд түүний ажигласан, тогтоосон нөхцөл байдал (гүйлгээнээс гадна харилцагчийн харилцаа, зан төлөв хэвийн байсан эсэх, нэг дор олон теллер сольж үйлчлүүлсэн эсэх гэх мэт) болон сэжиглэх үндэслэл нь СГТ-нд тусгагдсан байх нь чухал. Банкны теллер болон комплаенсын мэргэжилтэн хоёрын хоорондын харилцаа нь сэжиглэх үндэслэлийн суурийг баталгаажуулахад туслах боломжтой. Ингэснээр СГТ-нг СМА-нд мэдээлэхээс өмнө тухайн гүйлгээнд хууль, журмын дагуу нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг дотооддоо хянаж үзэх юм.

3.2 ХЭН МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан бүх МҮЭ /доор жагсаалтаар харуулав/ нь сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

4.1.1. БАНК;

4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;

- 4.1.3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
- 4.1.4. хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
- 4.1.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
- 4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;
- 4.1.7. харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
- 4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;
- 4.1.9. нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол:
 - 4.1.9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
 - 4.1.9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;
 - 4.1.9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
 - 4.1.9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
 - 4.1.9.д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

Гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг сэжигтэй байна гэж үзсэн тохиолдолд хэн тайлан бөглөх, хэн хянах, хэн эцсийн шийдвэр гаргах вэ гэдгийг банк өөрийн дотоод журам, хөтөлбөрт заасны дагуу шийдвэрлэнэ.

3.3 ЮУГ МЭДЭЭЛЭХ ВЭ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу СГТ дараах мэдээллийг агуулах шаардлагатай. Үүнд:

- *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан МҮЭ-ийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;*
- *харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;*
- *тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;*
- *тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;*
- *холбогдох бусад баримт бичиг.*

Банк нь хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор Сэжигтэй гүйлгээний тайлангаар СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

Хуульд заасан 24 цагийн шаардлага нь банкны ажилтан гүйлгээг шалгаж, дансанд хяналт тавих явцад тухайн гүйлгээг бодитой сэжиглэх үндэслэлтэй байна гэж үзсэн эсхүл мэдсэн цагаас тооцогдож эхэлнэ.

Банк нь харилцагчийн гүйлгээг СГТ-аар мэдээлсний дараа тухайн харилцагчтай бизнес харилцаагаа үргэлжлүүлж болно. Гэхдээ банк, түүний удирдлага, ажилтан нь СМА-нд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно. Өөрөөр хэлбэл, сэжигтэй гүйлгээний тухайд гүйлгээ, харилцагчийн мэдээллийг СГТ-аар СМА-нд мэдээлсэн тухай харилцагчид өөрт нь, мөн эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад этгээдэд хэлэх, мэдэгдэх, мэдээллийг дамжуулах, задруулах нь хуулиар хориглогдсон байдгийг анхаарах хэрэгтэй.

Банк шаардлагатай тохиолдолд уг СГТ-тай холбоотой нэмэлт мэдээллийг СМА-нд хүргүүлж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн холбогдох бусад заалтуудыг заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

3.4 ЯАЖ МЭДЭЭЛЭХ ВЭ?

Банк нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг СМА-нд мэдээлэхдээ “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-д заасны дагуу тайлан бэлтгэж, цахимаар мэдээлэх үүрэгтэй. СГТ-ийн маягтыг бөглөх дэлгэрэнгүй заавар, мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан “Тайлан бөглөх заавар, зөвлөмж”-д тусгасан байгаа болно.

4 ХАРИЛЦАГЧИЙН ТАЛААРХ БАРИМТ, МАТЕРИАЛЫГ ХАДГАЛАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу банк нь сэжигтэй гүйлгээ болон бусад бүх гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд хадгалах үүрэгтэй.

Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэлд сэжигтэй гүйлгээ, сэжигтэй гүйлгээ хийх оролдлогын талаарх мэдээлэл аль аль нь хамаарна.

Хуульд заасан 5 жилийн хугацаа нь сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлого хийгдсэнээс хойш тооцогдоно. Банк нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл болон түүнтэй холбогдох бусад баримт бичгийг СМА болон хуульд заасан бусад эрх бүхий байгууллагын мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай, тухайн гүйлгээтэй холбоотой мэдээллийг сэргээж харах боломжтой, холбогдох бүх мэдээллийг агуулсан байхаар хадгалах шаардлагатай.

5 УДИРДЛАГА БОЛОН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

Банк нь удирдах болон гүйцэтгэх шатны ажилтнууддаа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан хууль, эрх зүйн актууд болон байгууллагын дотоод бодлого, журмыг танилцуулах, эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн хангахтай холбоотой мэдээлэл, чиглэл, заавар өгөх сургалтыг дотооддоо тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан МҮЭ-ийн дотоод хяналтын хөтөлбөрт “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр”-ийг тусгаж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажиллахыг МҮЭ бүрт үүрэг болгосон байгаа. Мэдээж сургалтын хөтөлбөрийг ажилтнуудын хариуцсан ажил, чиг үүрэгт тохируулан ерөнхийлөн эсхүл тусгайлан ялгамжтай боловсруулсан байж болно. Хамгийн гол нь сургалтаар ажилтнуудын хийж байгаа ажил, үүрэгтэй холбогдох хууль, журам, байгууллагын журам, дотоод хяналтын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, цаашлаад тэдний мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмж, гүйцэтгэлийг сайжруулахыг зорьж, хөтөлбөрөө боловсруулах нь зүйтэй.

СГТ-нг мэдээлэхтэй холбогдох чиг үүргийг хэрэгжүүлж буй ажилтнуудын хувьд сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг таних, олж илрүүлэхэд сургах шаардлагатай. Үүнтэй холбогдуулан эдгээр ажилтнууд энэ гарын авлагад тусгасан сэжигтэй гүйлгээний түгээмэл жишээнүүд болон байгууллагынхаа гаргасан эсхүл олон улсын байгууллагуудаас гаргасан сэжигтэй гүйлгээний жишээнүүдийг уншиж мэдсэн, мөн банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэгддэг арга хэлбэр, типологийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болох нь зүйтэй.

Түүнчлэн сургалтаар хариуцсан ажилтнуудад сэжигтэй байж болзошгүй гүйлгээг илрүүлэх, сэжиглэх үндэслэлийг олж тогтоох зорилгоор гүйлгээ, харилцагчийг сонгох, шалгахтай холбогдуулан ямар арга хэмжээ авч, яаж ажиллах талаар дотооддоо авч хэрэгжүүлэх ажлын дэс дараалал, үйл явцыг тодорхой зааж, сургах шаардлагатай.

Банк, санхүүгийн салбарын бизнесийн орчин, харилцагч болон бүтээгдэхүүний төрөл, хэлбэр, ашиглагдах техник, технологи цаг үеэ даган өөрчлөгдөж байдаг тул сургалтын хөтөлбөрийг бий болох өөрчлөлттэй уялдуулан хууль, журамд орсон өөрчлөлтийг тусгаж тогтмол шинэчлэх шаардлагатай.

Сургалтаар МУТСТ-тэй холбоотой тавигдах хуулийн шаардлагууд, байгууллагын дотоод бодлого, үйл ажиллагаа болон сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн талаарх ажилтнуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхээс гадна ажилтан хуульд заасан үүргээ биелүүлээгүй буюу хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага, гарах үр дагаврын талаар, цаашлаад ажилтан болон байгууллага ямар ямар хариуцлага хүлээх (зөрчлийн шинжээс хамааран эрүүгийн, зөрчлийн хариуцлага хүлээх эсхүл Мөнгө угаах болон терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу арга хэмжээ авах гэх мэт) талаарх мэдлэг, мэдээллийг ажилтнуудад олгох хэрэгтэй.

Ийнхүү сургалт зохион байгуулах нь банкны хувьд МУТСТ хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүх шатанд хангахад маш чухал ач холбогдолтой. Гэхдээ ажилтнууд өөр өөр ажил үүргийн хуваарьтай тул сургалтыг хамааралтай, хамааралгүй бүх ажилтнуудад нэг хэлбэрээр хүргэхээс зайлсхийж, сургалтын хөтөлбөрөө МУТСТ-тэй холбоотой чиг үүрэг хэрэгжүүлдэг ажилтнуудад илүү нарийвчилсан, дэлгэрэнгүй байдлаар заахаар боловсруулж, зохион байгуулах нь илүү үр дүнтэй.

5.1 СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалт нь дараах агуулгыг хамарсан байвал зохино. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хянаж зохицуулах болсон талаарх ерөнхий мэдээлэл болон түүх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох, яагаад болон яаж үйлдэгддэг, яагаад энэ төрлийн гэмт хэргүүдийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх шаардлагатай талаарх мэдээлэл;
- Олон улсын стандарт, шаардлагууд;
- Банк, санхүүгийн салбарыг ашиглан Монгол Улсад болон бизнес, санхүүгийн харилцаа их хийгдэж байгаа улс орнуудад МУТС гэмт хэрэг үйлдэгдэж байгаа арга хэлбэр, хэв шинж, типологиуд;
- Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа МУТСТ хууль, журам болон зохицуулах, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын гаргасан гарын авлага, заавар зөвлөмж;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох Үндэсний эрсдэлийн үнэлгээ;
- Байгууллагын эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон МУТС-тэй холбогдох эрсдэлүүд;
- Банкны дотоод хяналтын нэгж болон хяналт тавих эрх бүхий байгууллагын хийсэн хяналт шалгалтаар илэрсэн МУТСТ-тэй холбоотой асуудлууд, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Банкны ажилтнуудын (теллер, үйлчилгээний ажилтан, комплаенсын ажилтан, бусад ажилтнууд, ахлах ажилтан, захирал, ТУЗ гэх мэт) МУТСТ-тэй холбоотой үүрэг, хариуцлага, чиг үүргээ хэрэгжүүлэх, ажлаа хийх явцад тулгарч болох түгээмэл асуудлуудыг шийдвэрлэх арга зам.

Жишээ нь:

- Сэжигтэй харилцагчид үйлчилгээ үзүүлэх болон сэжигтэй гүйлгээ хийх үед хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаар удирдамж, чиглэл өгөх;
- Харилцагч, гүйлгээг таньж мэдэхтэй холбогдуулан банкны ажилтны тавьсан асуулт, хүсэлтэд нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга өгөхөөс илт зайлсхийж буй харилцагчтай хэрхэн харилцах;
- Харилцагчийн мэдээллийг тодруулах, тулгаж баталгаажуулах болон харилцагчийг таньж мэдэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэх мэт банкны дотоод бодлого, үйл ажиллагааг таниулах;
- Хууль тогтоомжид заасан харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалахтай холбоотой зохицуулалтыг таниулах;

- Сэжигтэй гүйлгээг мэдээлэхэд тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгөх;
- Бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэхэд тавигдах шаардлагын талаар мэдээлэл өгөх;
- Ажилтнуудын хүлээх үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл өгөх;
- Банкны хэрэгжүүлэх МУТСТ хөтөлбөр болон дотоод бодлого, журмыг танилцуулах.

5.2 СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ БОЛОН ДАВТАМЖ

Сургалт нь зөвхөн шинээр орж ирсэн ажилтнуудад зориулан зохион байгуулдаг нэг удаагийн ажил биш, давтан зохион байгуулагддаг, төлөвлөгөөт ажил байх шаардлагатай. Сургалтыг олон хэлбэрээр, тогтмол зохион байгуулбал илүү үр дүнтэй. Сургалт зохион байгуулах олон арга хэлбэр байдаг бөгөөд заримыг нь энд дурдъя. Үүнд:

- Танхимын сургалт эсхүл банкны бүх ажилтнууд үе шаттайгаар ээлж дараалан хамрагдах боломжтой цахим сургалт зохион байгуулах;
- Бүх ажилтнуудад зориулан тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, журам, заавар, холбогдох бусад мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулах, цахим шуудангаар илгээх эсхүл сонин, сэтгүүл гэх мэт товхимол болгон нийтэлж хүргэх. Ингэснээр ажилтнууд хууль тогтоомж, байгууллагын дотоод бодлого, үйл ажиллагаа, эрсдэлийн талаар байнга мэдээлэлтэй байх боломжтой;
- Нэгж /газар, хэлтэс, алба гэх мэт/-ийн үйл ажиллагаатай холбоотой ажил, асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх уулзалт, хурлыг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол зохион байгуулах;
- Комплаенсын ажилтнууд (тухайн банкны болон бусад байгууллагын) бусад ажилтнуудад зориулан МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох мэдээлэл, заавар зөвлөмж өгөх сургалт эсхүл танилцуулга зохион байгуулах;
- Банкны удирдлагын багаас ажилтнуудад МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдох мэдээлэл, танилцуулга хийх;
- Удирдлагууд болон ажилтнуудад МУТСТ-тэй холбоотой тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар тогтмол мэдээлж байх байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулж танилцуулах.

6 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

6.1 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Харилцагчийн хийсэн, хийж байгаа, эсхүл хийх гэж байгаа гүйлгээ нь хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг эсхүл гэмт хэрэгтэнтэй холбоотой байж болзошгүй хэмээн сэжиг төрүүлэхүйц, анхаарал татсан хэв маяг, шинж байдалтай байж болно. Гүйлгээний ийм хэв маяг, шинж байдлыг ерөнхийд нь сэжигтэй гүйлгээний шинж тэмдэг гэнэ.

Банкны ажилтнууд эдгээр шинж тэмдгүүдийг, ялангуяа өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой сэжигтэй, анхаарал татахуйц шинж тэмдгүүдийг мэддэг, таньдаг байх нь чухал.

Энэ нь харилцагчийн гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого сэжигтэй байгаа эсэхийг тодорхойлоход тус дөхөм болох юм.

Гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого нь нэг эсвэл түүнээс дээш сэжигтэй байж болзошгүй шинж тэмдэгтэй байх нь тухайн гүйлгээ нь хууль бус үйл ажиллагаа, гэмт хэрэг эсхүл гэмт хэрэгтэнтэй холбоотойг нотлох мэдээлэл болж чадахгүй ч сэжиглэх үндэслэл байгааг илтгэнэ. Олон шинэ тэмдэгтэй байх нь тухайн гүйлгээ, харилцагчийг нэмж судлах шаардлагатай болохыг харуулж буй анхааруулах дохио гэж ойлгож болно. Ийм гүйлгээ, харилцагчийг комплаенсын ажилтан нарийвчлан шалгаж сэжиглэх бодитой үндэслэл байхгүй эсхүл байгаа эсэхийг шийдэх бөгөөд сэжиглэх үндэслэлтэй гэж үзвэл холбогдох журмын дагуу СМА-нд СГТ-аар мэдээлнэ.

Сэжигтэй гүйлгээний шинж тэмдгийн жагсаалтыг Хавсралт 1-д хавсаргав. Энэхүү жагсаалтыг 1/ Ерөнхий, 2/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог бүхий шинж тэмдгүүд гэсэн хоёр төрлөөр ангилсан болно. Жагсаалтыг ФАТФ, гадаад улс орны СМА болон бүхий байгууллагуудаас гаргасан бусад баримт бичиг, мөн өнгөрсөн хугацаанд МҮЭ-ээс СМА-нд мэдээлсэн сэжигтэй гүйлгээний мэдээлэлд үндэслэн боловсруулав.

САНАМЖ:

Хавсралт 1-д жагсаасан сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд нь жишээ болгон мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тохиолдож болох боломжит бүх хувилбарууд нь эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй болохыг анхаарна уу. Гэмт хэрэгтнүүд болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд өөр өөр салбар дахь сул талуудыг ашиглах зорилгоор, мөн шинэ техник, технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрэх тутам өөрсдийн зан байдал, үйлдэл, гэмт хэрэг үйлдэх арга хэлбэрээ байнга өөрчилдөг болохыг харгалзан банкны ажилтнууд мэдлэг мэдээлэлтэй, сонор сэрэмжтэй ажиллах хэрэгтэй.

7 СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

СМА нь СГТ-аар мэдээлэгдсэн сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлж шалгуулах шаардлагатай эсэхэд дүн шинжилгээ хийхийн тулд МҮЭ-ээс нэмэлт мэдээлэл авах шаардлагатай болдог. Нэмэлт мэдээлэл нь сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагаа нь аль нэг төрлийн гэмт хэрэгтэй холбоотой эсэх, тухайн гүйлгээ, мэдээллийг цааш нь шалгах, хүн хүч, цаг зав, хөрөнгө гэх мэт нөөц зарцуулах шаардлагатай эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг.

7.1 МУТСТ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ АВАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасны дагуу СМА нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар, данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар, банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг зэрэг нэмэлт мэдээллийг тус хуулийн 4.1-д заасан этгээдээс гаргуулан авах эрхтэй.

СМА-наас сэжигтэй гүйлгээний тухай нэмэлт мэдээлэл авах, банкинд хүсэлт хүргүүлэх арга, хэлбэр болон банкнаас хариу ирүүлэх арга, хэлбэр, хугацаа зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-326 дугаартай тушаалаар батлагдсан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл ирүүлэх журам”-д тодорхой тусгасан байгаа.

8 ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Банк нь сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг боловсруулах, илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой тодорхой, ойлгомжтой дотоод бодлого, журам, үйл ажиллагааны заавар болон хяналтын механизмтай байх шаардлагатай.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй бол зөрчлийн шинжээс хамааран МУТСТ тухай хуулийн 23 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйл, Эрүүгийн хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

9 МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ЗАДРУУЛАХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу МҮЭ, түүний удирдлага болон ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг тус хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

10 ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн хувь хүн болон хуулийн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.

12.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

12.3.Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1-д

заасан этгээд, түүний удирдлага, ажилтан болон Санхүүгийн мэдээллийн алба, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

_____оОо_____

ХАВСРАЛТ 1. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

1. ТҮГЭЭМЭЛ ШИНЖ ТЭМДГҮҮД

Дараах жишээнүүд нь сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогын түгээмэл шинж тэмдгүүдийн жишээ болно. Эдгээр жагсаалтыг жишээ, мэдээлэл болгон хүргүүлж байгаа бөгөөд сэжигтэй гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогын шинж тэмдгүүд эдгээр жишээгээр хязгаарлагдахгүй, мөн заавал дагаж мөрдөх албагүй болохыг анхаарна уу.

1.1. ЕРӨНХИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

- Харилцагч гэмт хэргийн үйл ажиллагаанд оролцож байгаа тухайгаа мэдээлсэн эсхүл хүлээн зөвшөөрсөн,
- Банкны ажилтан харилцагчийг мөрдөн шалгах ажиллагааны субъект болохыг мэдсэн,
- Харилцагч өөрийн гэрийн хаягаар ямар нэг мэдээлэл хүлээн авахаас татгалзсан,
- Харилцагч хэд хэдэн санхүүгийн байгууллагад тодорхой шалтгаангүйгээр олон данс эзэмшдэг,
- Харилцагч нь гүйлгээг мэдээлэгдэхээс зайлсхийх зорилгоор өөр өөр байршилд гүйлгээ хийх,
- Харилцагч нэг хаягийг байнга ашигладаг боловч гүйлгээнд тэмдэглүүлж байгаа нэрийг дахин дахин өөрчилдөг,
- Харилцагчийг хэн нэгэн дагалдаж явж байгаа эсвэл хэн нэгэн ажиглаж байгаа бол,
- Мэдэгдэж байгаа эсвэл бүртгэлтэй бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй, анхаарал татахуйц гүйлгээг олон давтамжтай хийх,
- Ажил эрхлэлтийн байдалтай нийцэхгүй, анхаарал татахуйц гүйлгээг олон давтамжтай хийх ,
- Хөрөнгө, мөнгөний эх үүсвэр/ гүйлгээний утга, зориулалтын талаар хамааралгүй эсвэл тодорхойгүй тайлбар өгөх,
- Мөнгөн дэвсгэрт нь хэвийн бус төлөв байдалтай байх, Жишээлбэл, чийгтэй, үнэртэй эсхүл ямар нэг бодисоор бүрхэгдсэн гэх мэт,
- Ажилтан эсхүл харилцагч сандарч, зохисгүй ааш араншин гаргах,
- Харилцагч банкны дотоод дүрэм журам, хяналтын талаар хэт лавшруулж сонирхох, асууж лавлах,
- Харилцагч тушааж байгаа мөнгөний дүнг тодорхой, яг таг мэдэхгүй байх,
- Харилцагч хийж буй гүйлгээнийхээ талаар тодорхойгүй, ойлгомжгүй мэдээлэл өгөх эсхүл гүйлгээний зорилгын талаар сайн мэдэхгүй байх,
- Харилцагч нь хийж байгаа өндөр дүнтэй гүйлгээгээ зохих ёсоор, хууль, журмын дагуу бүртгэлд оруулахаас зайлсхийж байгаа мэт ажиглагдах,

- Харилцагч гүйлгээний талаар хэт их тайлбар хийх,
- Харилцагч нүүр тулж уулзахад дурамжхан эсвэл дургүй байх,
- Харилцагч сандрах, гүйлгээ хийхдээ анзааргагүй царайлах,
- Харилцагч сэжигтэй гүйлгээнд оролцож байгаа хэдий ч мөнгө угаах үйл ажиллагаанд оролцож байгаа талаараа мэдээгүй царайлах,
- Харилцагч данс нээлгэсний дараа түүнтэй холбоо барих гэж оролдох үед харилцагчийн гэрийн эсвэл ажлын утас холбогдохгүй байх эсхүл бүртгүүлсэн утас нь ашиглалтад байхгүй байх,
- Шинээр бизнес/санхүүгийн харилцаа үүсгэсэн эсхүл үүсгэх гэж байгаа харилцагчийн мэдээллийг баталгаажуулахад хүндрэлтэй байх,
- Харилцагч гуравдагч этгээдийг төлөөлж байгаа мэт боловч энэ тухайгаа банк, санхүүгийн байгууллагын ажилтанд хэлэхгүй байх,
- Харилцагч тухайн хувь хүн, компанийн үйл ажиллагааны чиглэл, төрөлтэй үл нийцсэн үйл ажиллагаа явуулах эсхүл гүйлгээ хийх,
- Харилцагч гүйлгээг аль болох хурдан хийхийг шаардах,
- Харилцагчийн гүйлгээний талаараа өгч буй мэдээлэл, тайлбар нь авцалдаагүй, нөхцөл байдлаас зөрүүтэй байх,
- Гүйлгээ нь ойлгомжгүй байх эсвэл харилцагчийн хийдэг ердийн гүйлгээ, үйл ажиллагаатай нийцэхгүй байх,
- Харилцагч ойрын хугацаанд хэд хэдэн өөр санхүүгийн байгууллагуудтай шинэ харилцаа үүсгэсэн байдалтай байх,
- Харилцагч банкны ажилтантай ойр дотно харилцаа үүсгэхийг оролдох,
- Харилцагч ижил төстэй нэр эсвэл өөр боловч өмнөхтэй их төстэй хаяг ашиглах,
- Харилцагч гүйлгээ хийх болгондоо нэрээ үг үсгийг нь зөрүүлж өөрөөр хэлэх эсхүл бичих,
- Харилцагч бичиг баримтан дээрх гэрийн эсхүл ажлын хаягаа бичихийн оронд өөрөөр бичих, гүйцэд бичилгүй дутуу бичих,
- Харилцагч худал мэдээлэл өгөх эсхүл банкны ажилтны үнэн зөв гэж үзэхгүй байгаа мэдээлэл өгөх,
- Харилцагч энгийн бус эсвэл сэжигтэй байж болзошгүй гүйлгээ хийх, үйлчилгээ авахдаа банкны ажилтанд мөнгө, бэлэг, хахууль, тусламж санал болгох,
- Харилцагч бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр төлөхдөө хэвийн бус тамга, тэмдэг, тэмдэглэл бүхий замын чек гэх мэт төлбөр тооцооны хэрэгсэл ашиглахыг оролдох,
- Банкны ажилтан харилцагчийг мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдуулан мөрдөн

шалгагдаж буй этгээд гэдгийг мэдсэн,

- Банкны ажилтан найдвартай эх сурвалжаас (хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсвэл бусад нээлттэй эх сурвалж) харилцагчийг хууль бус үйл ажиллагаанд оролцсон гэж сэжиглэгдэж байгааг мэдсэн,
- Шинээр бүртгүүлсэн эсвэл бүртгүүлэх гэж байгаа харилцагч нь өмнө хууль зөрчиж байсан эсхүл гэмт хэрэгт холбогдож байсан,
- Гүйлгээг халхавч этгээд (ямар нэг хөрөнгөгүй, үйл ажиллагаа эрхэлдэггүй, эсхүл биетээр оршин тогтнодог гэх үндэслэлгүй этгээд) хийсэн эсхүл хийх гэж байгаа.

Гүйлгээг мэдээлэх эсвэл бүртгэхэд тавигдах шаардлагатай холбогдох

- Харилцагч банкны ажилтныг гүйлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг бөглөхгүй байх талаар ятгахыг оролдох,
- Харилцагч хийж байгаа гүйлгээгээ холбогдох байгууллагад мэдээлэгдэхээс зайлсхийж байгааг илэрхийлэхүйц асуулт асуух, хүсэлт тавих,
- Харилцагч сэжигтэй гүйлгээг мэдээлэхтэй холбоотой хууль, тогтоомжийн талаар маш сайн судалж, мэдсэн байх,
- Харилцагч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлыг сайн мэдэж байх,
- Харилцагч гүйлгээнд оролцож буй мөнгийг “цэвэр”, “хууль ёсны”, мөнгө

угаахтай холбоогүй” гэж сайн дураараа, асуугаагүй байхад шууд хэлэх,

- Харилцагч гүйлгээтэй холбоотой баримт бичгийг хадгалах, ХТМ үйл ажиллагаа хийгдэх болон гүйлгээг мэдээлэгдэхээс зайлсхийх зорилгоор гүйлгээний босго дүн буюу 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/-өөс бага дүнгээр олон хувааж гүйлгээгээ хийх,
- Харилцагч гүйлгээтэй холбоотой баримт бичгийг хадгалах, ХТМ үйл ажиллагаа хийгдэх болон гүйлгээний босго дүнгээс дээш дүнтэй гүйлгээ хийхээс зайлсхийх зорилгоор бусадтай хамтарч ажиллаж буй мэт харагдах.
- Харилцагч мэдээлэх шаардлагаас зайлсхийж байгаа мэт босго дүнгээс доогуур үнийн дүнтэй хоёр эсвэл түүнээс дээш бэлэн мөнгөний гүйлгээ хийх /энд хадгаламжийн даатгалд хамрагдах зорилгоор харилцагч хадгаламжаа 20 сая төгрөгөөс бага дүнтэй хэд хэд хуваах гүйлгээг энэ төрлийн гүйлгээнээс ялгаж ойлгох/.

Биеийн байцаалтын бичиг баримт

- Харилцагч эргэлзээтэй эсхүл дутуу мэдээлэл өгөх,
- Харилцагч илт хуурамч эсхүл дуурайлган хийсэн, өөрчилсөн мэт харагдах, үнэн зөв бус мэдээлэл бүхий бичиг баримт ашиглах,

- Харилцагч биеийн байцаалтын бичиг баримт өгөхөөс татгалзах,
- Харилцагч биеийн байцаалтын бичиг баримтын эх хувилбарыг бус зөвхөн хуулбарыг ашиглах,
- Харилцагч гадаадын улс орны, баталгаажуулах боломжгүй биеийн байцаалтын бичиг баримт ашиглах,
- Харилцагч өөрийн хувийн мэдээлэл бүхий биеийн байцаалтын бичиг баримтаас өөр бичиг баримт ашиглаж санхүү, бизнесийн харилцаа үүсгэхийг хүсэх,
- Харилцагчийн бүрдүүлж өгсөн баримт бичигт утасны дугаар гэх мэтчилэн хувийн чухал мэдээллүүд байхгүй байх,
- Харилцагч банкны ажилтанд байгууллагын мэдээлэл бүхий баримт бичгийг үзүүлэх, авчирч өгөхийг шалтгаангүй хойшлуулах, удаах,
- Биеийн байцаалтын бүх бичиг баримт нь гадаад улс орных эсхүл ямар нэг шалтгаанаар шалгаж, баталгаажуулж болохгүй байх,
- Биеийн байцаалтын бүх бичиг баримт нь шинээр авсан эсвэл саяхан шинэчлэгдсэн байх,
- Харилцагч авч байгаа үйлчилгээ, хийж байгаа гүйлгээний төрлөөс хамааран өөр өөр биеийн байцаалтын бичиг баримт ашиглах,
- Харилцагчаас биеийн байцаалтын бичиг баримт асуусны дараа гүйлгээгээ өөрчлөх,

- Харилцагч гүйлгээ хийх болгондоо өөр өөр биеийн байцаалтын бичиг баримт ашиглах,
- Харилцагч байгууллага нь бизнесийн үйл ажиллагааныхаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөс зайлсхийх.

Эдийн засгийн үндэслэл

- Гүйлгээ нь харилцагчийн санхүүгийн байдал эсхүл ердийн үйл ажиллагааны хэв маягтай нийцэхгүй байх,
- Гүйлгээ нь харилцагчийн ажил, бизнес эрхэлдэг салбарын хэвийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх эсхүл харилцагчийн хувьд эдийн засгийн ашиггүй мэт харагдах,
- Гүйлгээ нь гүйлгээний утга, зорилготойгоо нийцэхгүй, шаардлагагүй байхад хэт нарийн төвөгтэй байдлаар хийгдэх,
- Харилцагчийн хийж буй гүйлгээ, үйлдэл нь мэдүүлсэн эсхүл бүртгүүлсэн бизнесийн үйл ажиллагаанаасаа зөрүүтэй байх,
- Харилцагч байгууллага нь банк, санхүүгийн байгууллагаас санал болгосон бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөнгөлөлтийг авахаас татгалзах, үүнтэй холбогдуулан банк, санхүүгийн байгууллагаас асуусан мэдээллийг өгөхөөс татгалзах,
- Гүйлгээ, гүйлгээний зорилгыг тайлбарлах бодитой

- бизнесийн үйл ажиллагааны талаарх тайлбар байхгүй,
- Бизнесийн үйл ажиллагааны хувьд уялдаа холбоогүй аж ахуйн нэгжүүд хоорондоо гүйлгээ хийх эсхүл санхүүгийн харилцаанд орох (жишээ нь: хүнсний бүтээгдэхүүн импортлогч уул уурхайн машин механизмын сэлбэг, хэрэгсэл экспортлогчтой харилцах),

- Ашгийн бус эсхүл буяны байгууллагын хийсэн гүйлгээ нь тухайн байгууллага болон оролцсон талуудын үйл ажиллагаатай үл нийцсэн, хоорондоо ямар нэг холбоо хамааралгүй байх, эсхүл эдийн засгийн ямар ч үндэслэлтэй зорилгогүй байх.

1.2. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой дараах шинж тэмдгүүд нь сэжиглэх үндэслэлийг нэмэгдүүлж болно.

Бэлэн мөнгөний гүйлгээ

- Харилцагч өмнө хийсэн гүйлгээтэй харьцуулахад хэвийн бус их хэмжээний үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг олон давтамжтай хийх,
- Харилцагч нэрлэсэн дүн нь бага дэвсгэрт бүхий их хэмжээний мөнгөн тэмдэгтийг удаа дараа том дэвсгэртээр солиулах,
- Харилцагч бизнесийн үйл ажиллагаандаа үл нийцсэн, өмнө хийдэг байснаасаа өөр дүнтэй мөнгөн дэвсгэрт ашигласан,
- Харилцагч өөрийн ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагаатай нийцээгүй их хэмжээний бэлэн мөнгийг бусад валютаар байнга солих,
- Харилцагч ердийнхөөс өөрөөр боож, багласан их хэмжээний мөнгөөр гүйлгээ хийх,

- Харилцагч анхаарал татахуйц хуучин эсвэл маш бохир дэвсгэрт хадгалуулах,
- Харилцагч босго дүнгээс доогуур бэлэн мөнгөний гүйлгээ байнга хийх /энд хадгаламжийн даатгалд хамрагдах зорилгоор харилцагч хадгаламжаа 20 сая төгрөгөөс бага дүнтэй хэд хэд хуваах гүйлгээг энэ төрлийн гүйлгээнээс ялгаж ойлгох/,
- Харилцагч тоолоогүй мөнгө өгч гүйлгээ хийх. Тоолсны дараа харилцагч гүйлгээний дүнг мэдээлэх шаардлагатай мөнгөн дүнгээс доогуур болгон өөрчлөх,
- Харилцагч өмнөх гүйлгээтэй харьцуулахад хэвийн бус дүнгээр гүйлгээ хийх,
- Харилцагч өмнө хийдэг үйлдлээсээ өөрөөр замын чек, гадаад валют, эсхүл бэлэн мөнгө болж хөрвөх чадвартай бусад төлбөр тооцооны

- хэрэгсэл байн байн худалдаж авах,
- Дараалсан серийн дугаартай хэд хэдэн төрлийн бэлэн мөнгө болон төлбөрийн хэрэгслээр гүйлгээ хийх,
- Харилцагч өмнө хийдгээсээ өөрөөр их хэмжээний мөнгө эсвэл бусад хөрөнгө хадгалуулах эсвэл шилжүүлэх талаар асууж лавлах, ийм гүйлгээ хийх,
- Бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон хүмүүсийн хаяг нь бизнесийн үйл ажиллагаа явуулдаг хаяг байх эсхүл ажил эрхлэлтийн байдал (оюутан, ажилгүй, хувиараа бизнес эрхэлдэг)-тай нь нийцэхгүй байх,
- Харилцагчийн хийж байгаа бэлэн мөнгөний гүйлгээ нь ажил эрхлэлтийн байдал, ажил мэргэжил, үйл ажиллагааны төрөл, чиглэлтэй нийцэхгүй байх (тухайлбал, оюутан, эсхүл эрхэлсэн ажилгүй хүн өөр өөр газар зүйн байршилд өндөр дүнтэй бэлэн зарлагын гүйлгээ байнга хийх),
- Мөнгийг бэлэн мөнгө зөөвөрлөгчөөр тээвэрлүүлэх,
- Өөр өөр нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэртээр үлэмж их хэмжээний бэлэн гүйлгээ хийх,
- Мансууруулах бодис, хар тамхины хууль бус тариалан, үйлдвэрлэл, эсхүл худалдаа эрхэлдэг бүс нутагтай бизнесийн эсхүл хувийн харилцаатай харилцагч их хэмжээний бэлэн мөнгөөр орлогын гүйлгээ хийх,

- Харилцагчийн солиулахаар өгсөн чек үлдэгдэл хүрэлцэхгүй шалтгаанаар тогтмол буцаагдах,
- Хуурамч дэвсгэртээр гүйлгээ хийхийг завдах.

Дансаар дамжиж хийгдсэн гүйлгээ

- Монгол Улсад ажиллаж, амьдардаггүй хүн данс нээлгэх,
- Харилцагч тодорхой үндэслэл, шалтгаангүйгээр өөр хүний нэр дээр данс нээлгэх,
- Өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй маш төстэй нэрээр данс нээлгэх,
- Хуурамч нэрээр данс нээлгэх эсвэл ашиглахыг завдах,
- Бага дүнгээр олон удаагийн орлогын гүйлгээ хийгддэг бөгөөд өндөр дүнгээр цөөн удаа зарлагын гүйлгээ хийгддэг данс,
- Хэд хэдэн данс руу мөнгө орлогодож хийн дараа нь нэг дансанд төвлөрүүлээд гадаад улс руу шилжүүлэх,
- Харилцагч данс нээлгэсэн салбар, төвөөс гадна олон өөр газарзүйн байршилд байрлах салбар, нэгжээр байнга үйлчлүүлэх, энэ нь тухайн харилцагчийн эрхэлсэн ажил, үйл ажиллагаатай нийцэхгүй байх,
- Харилцагч нэг өдөр, нэг салбар, нэгжээр үйлчлүүлж хэд хэдэн гүйлгээ хийхдээ илэрхий өөр өөр теллерээр үйлчлүүлэх, үйлчлүүлэхийг завдах,

- Харилцагч дансны төрөл, зорилготой нийцэхгүй гүйлгээ тогтмол хийх,
- Эцэг эх, асран хамгаалагч эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хүүхдийн дансыг дансны зориулалтаас өөр зориулалтаар ашиглах,
- Харилцагч банкинд олон данс нээлгэсэн бөгөөд эдгээр данснуудын зарим нь урт хугацааны турш идэвхгүй байх,
- Харилцагч удаан хөдөлгөөнгүй буюу идэвхгүй байсан дансаараа гэнэт идэвхитэй гүйлгээ хийж эхлэх, энэ нь тухайн харилцагчийн эрхэлсэн ажил, бизнесийн үйл ажиллагаатай нь нийцэхгүй байх,
- Харилцагч дансандаа зөвхөн дансны доод үлдэгдэлтэй, идэвхгүй байсан дансандаа гэнэт өндөр дүнтэй нэг эсхүл хэд хэдэн орлогын гүйлгээ хүлээн авах, хүлээн авсан мөнгөө яг тэр дүнгээр нь эсхүл ойролцоо дүнгээр бэлнээр зарлагдаж авах,
- Харилцагчийн санхүүгийн бүтээгдэхүүн болон дансны хооронд тодорхой бус шилжүүлэг хийгдэх,
- Өөр өөр эх үүсвэрээс мөнгө татан төвлөрүүлж байгаа мэт нэг данснаас нөгөө руу их хэмжээний шилжүүлэг хийгдэх,
- Харилцагчийн данс руу гуравдагч этгээдээс олон удаагийн орлого хийгдэх,
- Босго дүнгээс доогуур дүн бүхий санхүүгийн хэрэгслээр (чек, мөнгөний ордер, бонд г.м) орлогын гүйлгээ тогтмол хийх,
- Корреспондент дансанд холбогддог харилцагч уг дансаар гадаад улсаас мөнгө хүлээн авмагц өөр улс руу буцааж шилжүүлэн уг дансыг дамжин өнгөрөх данс болгож ашиглах,
- Харилцагч өөрийн хувийн болон компанийн дансуудад их хэмжээний мөнгө хүлээн авч, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөртэй бүс нутаг, улс оронд байрлах цөөн тооны гадаад хүлээн авагчид шилжүүлэх.

Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна хийгдэх гүйлгээнүүд

- Харилцагч эсхүл гүйлгээнд оролцож байгаа бусад этгээд нь Монгол Улстай ямар нэг хамааралгүй байх,
- Хийгдэж байгаа гүйлгээ нь тодорхой шалтгаангүй олон улс орноор дамжиж буй бол,
- Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаггүй гадаадын банкнаас гаргасан зээлийн картыг тухайн картыг гаргасан улсад оршин суудаггүй, ажиллаж амьдардаггүй харилцагч ашиглаж гүйлгээ хийх,
- Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилчид авдаг дундаж цалин хөлснөөсөө хэтэрсэн их дүнтэй бэлэн болон гадаад шилжүүлгийн гүйлгээ хийх,
- Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилчдын тоотой харьцуулахад хэт их

гадаад шилжүүлгийн гүйлгээг энэ төрлийн харилцагчид хийх,

- Харилцагч мөнгөн гуйвуулгын шилжүүлэг тогтмол хийгддэггүй улс орнуудад байрлах гуравдагч этгээдийн данс руу их олон удаа гадаад шилжүүлгийн гүйлгээ хийх,
- Өндөр нууцлал бүхий банкны болон компанийн хууль, эрх зүйн системтэй улс орон руу гүйлгээ хийх,
- Харилцагч гадаад валют солиулан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөртэй бүс нутаг, улс орон руу шилжүүлэх,
- Харилцагч бэлэн эсхүл бэлэн бус орлого хийж, богино хугацааны дотор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөртэй бүс нутаг, улс орон руу эсхүл эдгээр улсаар дамжуулан гадаад шилжүүлэг хийх,
- Хууль бусаар мансууруулах бодис, хар тамхи тариалдаг, үйлдвэрлэдэг, экспортлодог байж болзошгүй эсхүл мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй тогтолцоогүй улс орон руу гүйлгээ хийх,
- Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгддэг гэж танигдсан эсхүл сэжиглэгддэг улс орон руу гүйлгээ хийх.

Оффшор бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гүйлгээ

Гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийдэг банк, санхүүгийн байгууллагууд нь сэжигтэй

гүйлгээний дараах шинж тэмдгүүдийг харгалзаж үзвэл зохино. Үүнд:

- Харилцагч бизнесийн цар хүрээ, дансаар хийдэг гүйлгээний эргэлттэйгээ нийцэхгүй их хэмжээний мөнгө харимтлуулж богино хугацааны дотор оффшор бүс дэх улс руу шилжүүлэх,
- Харилцагч аяллын чек, гадаад валют, төлбөр тооцооны бусад хэрэгсэл худалдан авах хүсэлт тогтмол гаргах,
- Оффшор банкнаас хүлээсэн үүргээр баталгаажсан зээл,
- Оффшор бүсэд байрлах компанид зээл олгох эсхүл зээл авах,
- Оффшор бүсэд байрлах банкаас нууцалсан эх үүсвэрээс олон сая долларын орлогын гүйлгээ хийх хүсэлт гаргах эсхүл оффшор банкнаас баталгаа гаргах,
- Хууль ёсоор оршин тогтнож, үйл ажиллагаа явуулдаг томоохон байгууллагын нэртэй төстэй нэр бүхий оффшор “халхавч” банкаар дамжуулан гүйлгээ хийх,
- Харилцагч эх үүсвэр, зорилго тодорхойгүй мөнгийг гадаад улсаас цахим шилжүүлгээр хүлээн авч, буцаагаад цахимаар гадагш шилжүүлэх,
- Харилцагч аккредитив болон худалдааны санхүүжилтийн бусад хэрэгсэл ашиглан улс хооронд мөнгө шилжүүлэх бөгөөд энэ нь тухайн харилцагчийн бизнесийн үйл ажиллагаатай үл нийцэх,

- Оффшор бүсэд байрлах банкнаас гаргасан кредит карт ашиглах.

Хувийн гүйлгээ

- Харилцагч нэг газар зүйн бүс нутагт байрлах хэд хэдэн санхүүгийн байгууллагад данс эзэмшдэг байх,
- Харилцагч ажил эрхлэлтийн түүхгүй боловч байнга өндөр дүнтэй гүйлгээ хийх эсвэл данс нь байнга өндөр дүнтэй үлдэгдэлтэй байх,
- Дансаар эргэлдэж байгаа мөнгө, орж ирж буй орлого нь данс эзэмшигчийн бүртгүүлсэн ажил мэргэжил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл дансны зориулалттай үл нийцэх,
- Харилцагч гадаадын корреспондент банкны (дамжин өнгөрөх данс) ерөнхий данс руу нэг эсвэл олон удаа бэлэн мөнгөөр орлогын гүйлгээ хийх,
- Харилцагч цахим банкны үйлчилгээ ашиглан өндөр дүнтэй гүйлгээг тогтмол хийх,
- Харилцагчийн кредит карт байнга өндөр дүнтэй үлдэгдэлтэй байх, банк санхүүгийн байгууллагад их хэмжээний хүү, алданги төлөх бөгөөд энэ нь харилцагчийн ажил, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй, эдийн засгийн үр ашиггүй байх,
- Харилцагч кредит картнаас бэлэн мөнгө авч төлбөр тооцооны хэрэгсэл худалдан

авах эсхүл гадаад улс руу шилжүүлэг хийх,

- Харилцагч кредит картнаас бэлэн мөнгө авч хадгаламж эсхүл харилцах дансандаа орлогодох,
- Харилцагч кредит картны төлбөрөө тодорхой шалтгаангүй нэг дор их хэмжээний бэлэн мөнгөөр төлөх,
- Харилцагч кредит картны төлбөрөө зээлийн эрхийн дээд хэмжээнээс илүү буюу хэтрүүлэн төлөх, дараа нь картнаас бэлэн мөнгө авах,
- Харилцагч бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийхийн яг өмнө хадгаламжийн хайрцаг /үнэт зүйл хадгалах хайрцаг/-аар үйлчлүүлэх ,
- Харилцагч банкнаас дебит эсхүл кредит карт авахдаа өөрийн хаягаас өөр дотоод, гадаад хаяг руу илгээхийг хүсэх,
- Харилцагч өөрийн эзэмшдэг олон тооны дансууд руу өндөр дүнтэй бэлэн мөнгөний орлого хийх,
- Харилцагч гуравдагч этгээдийн нэр дээр олгогдсон өндөр дүнтэй чек солиулж орлогын гүйлгээ хийх,
- Харилцагч өөрийн ажилтан эсхүл гэр бүлийн гишүүн биш хувь хүний данс руу тогтмол орлогын гүйлгээ хийх,
- Харилцагч гадаад валют байнга солиулах бөгөөд энэ нь харилцагчийн ажил, бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх,

- Харилцагч АТМ ашиглан босго дүнгээс доогуур дүнтэй орлогын гүйлгээ байнга хийх,
- Харилцагчийн хадгаламжийн хайрцаг /үнэт зүйл хадгалах үйлчилгээ/ ашиглах нь эрс нэмэгдэх, энэ нь харилцагчийн энэ төрлийн үйлчилгээг өмнө авч байсан түүхтэй харьцуулахад хэвийн бус байх,
- Хоорондоо холбоо хамааралгүй олон тооны хүмүүс тодорхой шалтгаан, тайлбаргүйгээр нэг данс руу орлогын гүйлгээ хийх,
- Харилцагчийн кредит картны данс руу гуравдагч этгээд кредит картны төлбөр эсхүл орлогын гүйлгээ хийх,
- Харилцагч хамаатан садан биш хүнд өөрийн данснаас өндөр дүнтэй гүйлгээ хийх итгэмжлэл өгөх,
- Харилцагч хөрөнгө борлуулсан орлого хэмээн орлогын гүйлгээ байнга хийж байгаа ч хөрөнгө борлуулсан эсэх нь нотлогдохгүй байх,
- Харилцагч их хэмжээний хөрөнгө худалдан авч байгаа боловч тодорхой тайлбар, шалтгаангүйгээр богино хугацааны дотор буцааж худалдах,
- Харилцагч өндөр дүнтэй хөрөнгө худалдан аваад эдийн засгийн үр өгөөжгүй, ашиггүй байдлаар барьцаанд тавьж зээл авах,
- Харилцагч эдийн засгийн үндэслэлгүй, үр ашиггүй байдлаар мөнгө шилжүүлэх хүсэлт тавих,
- Харилцагч дансаараа хэт өндөр дүнтэй цахим шилжүүлэг хүлээн авах, шилжүүлэх,
- Мөрийтэй тоглоомоос хожсон мөнгийг дансандаа тогтмол орлогодож, тэр даруй зарлагын гүйлгээ эсвэл шилжүүлэг хийх,
- Харилцагч МУТСТ сул тогтолцоотой улс орнуудаар дамжуулан гүйлгээ хийх.

Байгууллага болон бизнесийн үйл ажиллагааны гүйлгээ

Зарим бизнесийн үйл ажиллагааны хувьд хууль бус хөрөнгө, мөнгийг хууль ёсны орлоготой нийлүүлэх бололцоо өндөр байдаг бөгөөд энэ нь мөнгө угаахад ашиглагддаг хамгийн нийтлэг арга юм. Энэ төрлийн бизнес эрхлэгчид нь ресторан, зоогийн газар, автомашины зогсоол, сүлжээ дэлгүүрүүд, автомат худалдааны машин гэх мэт үйл ажиллагааныхаа дийлэнх хэсгийг бэлэн мөнгөөр хийдэг бизнес эрхлэгчид байдаг. Банк, санхүүгийн байгууллагууд нь бизнес эрхлэгчид болон хуулийн этгээд данс нээлгэх үед тухайн бизнесийн үйл ажиллагаа бэлэн мөнгөнд суурилсан буюу бэлэн мөнгө түлхүү ашигладаг эсэхийг мэдэх хэрэгтэй.

- Бизнес эрхлэгч, хуулийн этгээдийн хийж байгаа орлогын дүн, давтамж нь хэвийн бус эсхүл тодорхой тайлбар, шалтгаангүйгээр гэнэт өсөх нь сэжигтэй үйл ажиллагааны шинж тэмдэг байж болзошгүй,
- Цалин төлөх, нэхэмжлэлийн дагуу бизнесийн үйл ажиллагааны төлбөр

- шилжүүлэх гэх мэт энгийн бизнесийн үйл ажиллагаатай холбоогүйгээр дансаараа өндөр дүнтэй мөнгө хүлээж авах эсхүл мөнгө шилжүүлэх,
- Харилцагчийн эрхэлдэг үйл ажиллагаатай нийцэхгүй өндөр дүнтэй бэлэн, бэлэн бус орлогын гүйлгээ хийгдэх,
 - Харилцагчийн дансанд хууль ёсны бизнесийн үйл ажиллагаатай нь нийцэхгүй олон төрлийн мөнгөний хэрэгслээр орлого хийгдэх,
 - Харилцагчийн дансанд бизнесийн үйл ажиллагаатай нь холбогдолгүй бэлэн мөнгө болон мөнгөний хэрэгсэл хосолсон орлого хийгдэх,
 - Харилцагч нь салбарын болон бизнесийн үйл ажиллагааны төрөл, чиглэлтэй нийцэхгүй олон төрлийн данс эсвэл трастын данс нээлгэж ашиглах,
 - Бизнес эрхлэгч нь өөрийн эрхэлдэг бизнесийн үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл өгөхгүй байх,
 - Бизнес эрхлэгчийн санхүүгийн тайлан нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагынхаас илт зөрүүтэй байх,
 - Бизнес эрхлэгч эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь банкны салбар дээр биечлэн ирж гүйлгээ хийхээс аль болох зайлсхийх,
 - Байгууллагын дансаар бэлэн бус гүйлгээ хийхээс илүү бэлэн мөнгөөр гүйлгээ хийх,
 - Харилцагч олон тооны харилцах, хадгаламж, трастийн гэх мэт өөр өөр төрлийн данс эзэмшиж, ашиглах, энэ нь тухайн харилцагчийн эрхэлж буй бизнесийн төрөл, ажиллаж буй салбарын хэвийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх,
 - Харилцагч байгууллага нь чек бэлэн мөнгө болгох үйлчилгээ үзүүлдэг жижиг бизнес эрхэлдэг хэдий ч чекээр орж ирсэн орлоготой дүйцэхүйц дүнтэй бэлэн мөнгөний зарлага гаргахгүй байх,
 - Харилцагч төлбөрийн хэрэгсэл, төлбөр тооцооны бусад хэрэгсэл худалдан авах эсвэл шилжүүлэг хийхдээ ихэвчлэн бэлэн мөнгө ашиглах,
 - Харилцагч багцалсан их хэмжээний бэлэн мөнгөөр орлогын гүйлгээ хийх,
 - Харилцагч хэд хэдэн дансуудад хоорондоо хамааралгүй өндөр дүнгээр орлого хийх, дийлэнх хэсгийг нь данс байршиж буй банк эсхүл өөр банкин дахь нэг данс руу тогтмол шилжүүлэх,
 - Харилцагч бэлэн мөнгө ашигладаггүй бизнесээс өндөр дүнтэй бэлэн мөнгөний орлого, шилжүүлэг хүлээн авах,
 - Харилцагч бэлэн мөнгөний гүйлгээ тогтмол хийдэггүй байгууллагын данснаас өндөр дүнтэй бэлэн зарлагын гүйлгээнүүд хийх,
 - Харилцагч гадаад улсаас өндөр дүнтэй орлого дансанд орж ирсэн даруйд өндөр дүнтэй бэлэн зарлагын гүйлгээ тогтмол хийх,

- Харилцагч нэрлэсэн дүн өндөр, их хэмжээний мөнгөн тэмдэгтээс бүрдсэн бэлэн мөнгөний орлогын гүйлгээг нэг эсхүл түүнээс олон удаа хийх,
- Жижиг хэмжээтэй, нэг газар зүйн байршилд үйл ажиллагаа явуулдаг байгууллага ажлын нэг өдөр банкны олон өөр байршил (орон нутаг) дахь салбараар дамжуулан орлогын гүйлгээ хийх, энэ нь тухайн байгууллагын өмнө хийж байсан гүйлгээтэй нийцэхгүй байх,
- Байгууллагын дансанд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас гэнэт их хэмжээтэй эсвэл олон удаа бэлэн, бэлэн бус орлогын гүйлгээ/шилжүүлэг хийгдэх, орж ирсэн мөнгийг хүлээн авагч байгууллага тэр дор нь данснаасаа шилжүүлэх,
- Бэлэн мөнгөөр хийж буй гүйлгээний дүн эсвэл хэлбэрт гэнэт өөрчлөлт орох,
- Харилцагч өөрийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг хаягаас өөр дотоодын эсвэл гаднын хаяг руу кредит эсвэл дебит карт илгээхийг хүсэх,
- Гүйлгээний хэмжээ, дүн эрс нэмэгдэх, дансны үлдэгдэлд мэдэгдэхүйц өөрчлөлт орох бөгөөд энэ нь харилцагчийн дансаар хийгддэг гүйлгээ болон бизнесийн үйл ажиллагаатай нийцэхгүй байх,
- Хөрөнгө худалдан авалт нь нийтлэг бус барьцаалбартай байх,
- Хувийн болон компанийн данс хооронд олон удаа тодорхойгүй гүйлгээ хийх,
- Үйл ажиллагаа нь мэдүүлсэн үйл ажиллагаанаасаа ялгаатай байх,
- Харилцагчийн данс бусад этгээдийн данстай тодорхойгүй шалтгаанаар харилцаатай байх,
- Гүйлгээ нь хөрөнгийн зах зээлийн болон бизнес үйл ажиллагаатай нийцэхгүй, зохицуулалтыг зөрчихөөр байх,
- Бизнесийн эсвэл бусад эдийн засгийн тодорхой зорилгогүйгээр их хэмжээний өндөр дүнтэй орлого/ зарлагын гүйлгээ хийх, ялангуяа гүйлгээ хийж байгаа бүс нутаг нь мөнгө угаах эрсдэлтэй/ хяналтын сул тогтолцоотой бүс нутаг бол.

Цахим мөнгөн шилжүүлэг

- Харилцагч хийж буй мөнгөн гуйвуулгатай холбоотой мэдээлэл, тайлбар өгөхдөө дурамжхан байх, дургүйцэх,
- Харилцагчийг таних эсвэл мэдээлэх шаардлагаас илт зайлсхийх зорилгоор бага дүнтэй цахим шилжүүлэг хийх,
- Харилцагч бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийдэг гадаадын байгууллага руу өндөр дүнтэй төлбөр шилжүүлэх,
- Харилцагч бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх тогтолцоотой гадны улсаас

- өндөр дүнтэй мөнгөн шилжүүлэг хүлээж авах,
- Харилцагч нь өөртэйгээ хамааралгүй хувь хүн, хуулийн этгээд рүү тогтмол өндөр дүнтэй мөнгө шилжүүлэх,
- Харилцагч нь өөртэйгээ хамааралгүй хувь хүн эсвэл хуулийн этгээдээс тогтмол өндөр дүнтэй мөнгөн шилжүүлэг хүлээж авах,
- Харилцагч мөнгөн шилжүүлэг хүлээн авсны дараа өөртэйгээ хамааралгүй гуравдагч этгээд руу төлбөр шилжүүлэх зорилгоор төлбөрийн хэрэгсэл худалдаж авах,
- Харилцагч өндөр дүнтэй шилжүүлэг хүлээн авсан даруйд шууд бэлэн мөнгөөр төлбөр төлөх хүсэлт тавих,
- Харилцагч банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан гадны улс руу шилжүүлэг хийх, мөн ижил хэмжээний мөнгө шилжиж орж ирэх талаар мэдэгдэх,
- Шилжүүлэг харилцагчийн данс руу ормогц өөр данс эсвэл өөр хувь хүн, хуулийн этгээдийн данс руу шилжүүлэх,
- Харилцагч мөнгөн шилжүүлэг хийгдэх систем, ерөнхий нөхцөл эсвэл шилжүүлж болох мөнгөн дүнгийн хязгаарын талаар ердийн бус байдлаар асууж, лавлах,
- Харилцагч өөр улс руу мөнгөн шилжүүлэг хийхдээ валютын төрөл өөрчлөхгүйгээр шилжүүлэх,
- Гадаад улсаас орж ирсэн цахим мөнгөн шилжүүлгийг байгууллагын удирдлагууд нэн даруй зарлагадах,
- Харилцагч тодорхой бизнесийн харилцаа, холбоо хамааралгүй улс руу байнга цахим мөнгөн шилжүүлэг хийх,
- Харилцагч тодорхой бизнесийн харилцаа, холбоогүй хуулийн этгээдээс цахим мөнгөн шилжүүлэг хүлээн авах,
- Шилжүүлгийн гүйлгээний дүн нь харилцагчийн өмнө хийж хэвшсэн бизнесийн гүйлгээтэй нийцэхгүй байх,
- Мөнгөн шилжүүлгийн дүн, хэмжээ нь харилцагчийн дансны болон бизнесийн мэдэгдэж буй үйл ажиллагаатай нийцэхгүй өсөх,
- Хэд хэдэн харилцагч нэг ажлын өдөр эсвэл 2-3 хоногийн дотор нэг хүлээн авагч руу шилжүүлэг хийх,
- Нэг харилцагчийн шилжүүлгийг өөр өөр харилцагчид хүлээн авах,
- Хэд хэдэн харилцагч шилжүүлэг хийхдээ нэг ижил мэдээлэл /овог, хаяг, утасны дугаар гэх мэт/ ашиглах,
- Хэд хэдэн харилцагч мөнгөн шилжүүлэг хийхдээ ижил мөнгөн дүнгээр, нэг ижил нэр ашиглан ижил асуулт эсвэл мессеж бүхий шилжүүлгийг нэг улс руу шилжүүлэх,
- Харилцагч нь нэг хувь хүнээс олон гүйлгээ хүлээж авах эсвэл олон шилжүүлэг шилжүүлэх,

- Харилцагчийн мэдүүлсэн ажил, бизнес, санхүүгийн байдал нь үйл ажиллагаа, орлоготой нь нийцэхгүй байх (жишээлбэл оюутан эсвэл ажилгүй иргэн олон тооны шилжүүлэг хийх).
- Байнгын оршин суугч бус иргэн нь түгээмэл ашиглагддаг мөнгөн гуйвуулгын сувгаас өөр суваг ашиглан шилжүүлэг хийх,
- Харилцагч цалингийн орлоготойгоо үл нийцэх шилжүүлэг хийх,
- Шилжүүлгийг хүлээн авах улс нь тухайн харилцагчийн харьяалагддаг улс биш байх,
- Харилцагч гадаад улс руу гэр бүлийн гишүүн биш олон тооны хүмүүс руу өндөр дүнтэй шилжүүлэг хийх,
- Харилцагч нь мөнгөн шилжүүлэг хүлээн авч буй хүнийг мэдэхгүй байх,
- Шилжүүлэг хүлээн авсан харилцагч шилжүүлэг хийсэн хүнийг мэдэхгүй байх,
- Цахим гүйлгээг хүлээн авагчид нь террорист үйл ажиллагаа их хийгддэг гэж танигдсан улсуудын харьяалал бүхий хэсэг бүлэг этгээд байх,
- Харилцагч гадаад улсад байрлах өөрийн бизнесийн үйл ажиллагаатай нь холбоо хамааралгүй бусад этгээд руу мөнгө шилжүүлэх,
- Харилцагч нь мансууруулах бодисны хууль бус тариалан, үйлдвэрлэл, эсхүл худалдаа эрхэлдэг эсхүл дамжин өнгөрүүлдэг бүс нутаг гэж танигдсан улс орон руу эсвэл банкны болон байгууллагын маш өндөр нууцлал бүхий хууль, эрх зүйн тогтолцоотой улс орон руу шилжүүлгийн гүйлгээ хийх, шилжүүлэг хүлээн авах,
- Харилцагч нь банктай биечлэн харилцахгүй, зөвхөн интернет / цахим банкны (төлбөр тооцооны) үйлчилгээ ашиглан өндөр дүнтэй гүйлгээ хийх,
- Монгол Улсын банк, санхүүгийн байгууллагад нээлгэсэн харилцагчийн данс руу гадаад улс орнуудаас интернет банкны үйлчилгээг тогтмол ашиглан гүйлгээ хийх.

Зээл

- Харилцагч зээлээ тодорхой шалтгаангүйгээр хугацаанаас нь өмнө гэнэт төлөх,
- Харилцагч өндөр дүнтэй зээлийн төлбөрөө тодорхой бус санхүүгийн эх үүсвэрээс эсвэл банкин дахь тухайн харилцагчийн орлогын эх үүсвэрийн мэдээлэлтэй тохирохгүй өөр эх үүсвэрээс олсон мөнгөөр гэнэт төлөх,
- Харилцагч орон сууцны зээл гэх мэт урт хугацаатай зээлийг харьцангуй богино хугацаанд бүтэн төлөх,
- Зээлийн урьдчилгаа төлбөрийн эх үүсвэр нь зээлдэгчийн ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон орлоготой нийцэхгүй байх,
- Харилцагчийн зээлийн урьдчилгаа төлбөрийг

- түүнтэй холбоо хамааралгүй гуравдагч этгээд төлөх,
- Харилцагч өөр санхүүгийн байгууллагаас гаргасан төлбөрийн хэрэгслээр урьдчилгаа төлбөрийг хийх,
 - Харилцагч зээл хүссэн анкетан дээр “гадаад эх үүсвэр”-ээс олсон орлого мэдүүлэх, энэ талаар тодорхой тайлбар өгч чадахгүй байх,
 - Харилцагч өөрийн ажил олгогчийг тодорхойлох хаяг, холбоо барих утас зэрэг чухал мэдээллүүдийг ажил эрхлэлтийн байдал хэсэгт дурдаагүй байх,
 - Харилцагчийн биеийн байцаалт, орлого, ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлох баримт бичгийг харилцагчтай тодорхой хамааралгүй гуравдагч этгээд гаргасан байх,
 - Харилцагч өөрийн бизнесийн чиглэлтэй хамааралгүй өөр байгууллага эсвэл оффшор бүсэд байрлах байгууллагаас авсан зээлтэй байх,
 - Харилцагч банк, санхүүгийн байгууллагад зээлийн хүсэлтийг нь хүлээн авч зээл олгосны хариуд их хэмжээний долларын хадгаламж байршуулах эсвэл бусад төрлийн урамшуулал өгөх санал тавих,
 - Харилцагч өөр санхүүгийн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн эзэмшилд байгаа эх үүсвэр нь тодорхойгүй хөрөнгийг барьцаалан зээл авахыг хүсэх,
 - Харилцагч эдийн засгийн үндэслэлгүй зээл хүсэх (жишээлбэл, харилцагч хангалттай хөрөнгөтэй бөгөөд ямар нэг зээл авах бизнесийн шаардлага байхгүй),
 - Харилцагч зээл хүсэхдээ зээлийн ерөнхий нөхцөл, хүүний хэмжээ, зээлтэй холбогдон гарах бусад зардлын талаар тоохгүй, асууж лавлахгүй байх,
 - Харилцагч нь банк болон байгууллагын нууцлал өндөртэй улсаас орж ирж буй орлого эсвэл хөрөнгө оруулалтыг тусгасан санхүүгийн тайланд тулгуурлан зээл хүсэх, энэ нь харилцагчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлтэй нийцэхгүй байх,
 - Харилцагчтай хамааралгүй этгээд зээлийн төлбөр эсвэл урьдчилгаа төлбөрийг хийх,
 - Өөрт нь ашигтай, таатай нөхцөл олгох зээлийн бүтээгдэхүүн санал болгосоор байтал ашиглахгүй, эдийн засгийн үр ашиггүй бүтээгдэхүүн хүсэх,
 - Харилцагчийн данс руу дотоодын компани эсвэл траст данснаас өөр санхүүгийн байгууллагаас гаргасан төлбөр тооцооны хэрэгсэл ашиглан төлбөр хийх,
 - Зээлийн данс руу зээл эргэн төлөх хуваарьт зааснаас их дүнтэй бэлэн төлбөр тодорхой шалтгаангүйгээр тогтмол эсвэл үе үе хийх.

Ашгийн бус байгууллага (буяны байгууллага)-ын гүйлгээ

- Гэмт хэрэг үйлдсэн эсвэл сэжиглэгдэж байгаа этгээд буяны байгууллагын нэрээр траст эсвэл банкны данс нээлгэх,
- Байгууллагын зорилго, үйл ажиллагаатай гүйлгээний төрөл, хэмжээ нийцэхгүй байх,
- Дансандаа удаан хугацааны турш мөнгө хадгалах, эсвэл байгууллагын дансаар хийгдэх гүйлгээний давтамж, хэмжээ гэнэт нэмэгдэх,
- Ашгийн бус байгууллага нь тодорхой зорилгогүй өндөр дүнтэй бэлэн мөнгөөр гүйлгээ хийх,
- Монгол Улсад бүртгэлтэй донор/хандивлагчдийн хувь нэмэр байхгүй байх,
- Тодорхой хамааралгүй олон тооны ашгийн бус байгууллага хоорондоо санхүүгийн харилцаа үүсгэх,
- Ашгийн бус байгууллага нь мэдүүлсэн зорилго болон санхүүгийн нөхцөл байдалтайгаа нийцэхгүй цөөн ажилтантай эсвэл огт ажилтангүй байх, эсвэл тогтсон үйл ажиллагаа явуулах оффисгүй, эсвэл холбогдох утасны дугааргүй байх,
- Ашгийн бус байгууллага нь өндөр эрсдэлтэй улс оронд үйл ажиллагаа явуулдаг эсвэл тийм улстай холбогдсон гүйлгээ хийх,
- Ашгийн бус байгууллагын хөрөнгө, мөнгөний эх сурвалж болон цуглуулсан хөрөнгө, мөнгөний хэмжээ нь хоорондоо уялдаж нийцэхгүй байх,
- Гүйлгээний хэмжээ, давтамж, төрөл нь ашгийн бус байгууллагын үйл ажиллагаа, зорилготой нийцэхгүй байх,
- Дансандаа удаан хугацааны турш мөнгө хадгалах, эсвэл байгууллагын дансаар хийгдэх гүйлгээний давтамж, хэмжээ гэнэт нэмэгдэх,
- Зорилго нь тодорхойгүй өндөр дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийх,
- Монгол Улсад бүртгэлтэй донор/хандивлагчдийн хувь нэмэр байхгүй байх,
- Байгууллагын удирдлага / төв нь Монгол Улсаас өөр улсад байрладаг бөгөөд удирдлага / төвийн байрладаг улс руу их хэмжээний гүйлгээ хийх, ялангуяа тухайн улс нь өндөр эрсдэлтэй улс байх.

2. САЛБАРЫН ОНЦЛОГ ШИНЖ ТЭМДГҮҮД

БЭЛЭН МӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ БИЗНЕС (МӨНГӨН ГУЙВУУЛГА, ЭСВЭЛ ВАЛЮТ СОЛИХ ҮЙЛЧИЛГЭЭ)

- Харилцагч мөнгөн гуйвуулга хийхдээ тодорхой шалтгаангүйгээр өөр өөр байршилд байх олон тооны агент, салбар ашиглах,
- Гадаад улс дахь нэг хүлээн авагч руу олон харилцагч гадаад мөнгөн гуйвуулга хийх,
- Мөнгийг хувааж хийж байж болзошгүйг илтгэх олон тооны бага дүнтэй гадаад мөнгөн гуйвуулга хийх,
- Хэд хэдэн харилцагч нэг ажлын өдөр эсвэл 2-3 хоногийн зайтай нэг хүлээн авагч руу мөнгөн гуйвуулга хийх,
- Харилцагч нь мөнгөн гуйвуулгыг хүлээн авч байгаа хүнийг мэдэхгүй байх,
- Харилцагч нь мансууруулах бодисны хууль бус тариалан, үйлдвэрлэл, эсхүл худалдаа эрхэлдэг эсхүл дамжин өнгөрүүлдэг бүс нутаг гэж танигдсан улс орон руу эсвэл банкны болон байгууллагын маш өндөр нууцлал бүхий хууль, эрх зүйн тогтолцоотой улс орон руу мөнгөн гуйвуулга хийх, хүлээн авах,
- Харилцагч холбоо хамааралгүй улс руу тогтмол мөнгөн гуйвуулга хийх,
- Харилцагч нь гадаад валютыг хамгийн том дэвсгэртээр солиулж авахыг хүсэх,
- Харилцагч нь гуйвуулга хүлээн авагчийн хаяг, холбоо барих утасны талаар сайн мэдэхгүй байх, энэ төрлийн мэдээллийг мэдээлэх дургүй байх эсвэл шилжих төлбөрийн хэрэгсэл (bearer instrument) худалдаж авах хүсэлт гаргах,
- Харилцагч нь мөнгөн гуйвуулга хүлээн авагчийн оронд өөр гуравдагч этгээд хүлээн авах талаар мэдэгдэх,
- Харилцагч нь аялалын зорилготойгоо нийцэхгүй их хэмжээний үнийн дүнтэй аялалын чекийг худалдан авах,
- Харилцагч нь их хэмжээний гадаад валютыг өөр улсын валютаар солиулах,
- Харилцагч нь их хэмжээний аялалын чек худалдах/солиулах,
- Харилцагч нэрлэсэн дүн нь бага дэвсгэрт бүхий их хэмжээний мөнгөн тэмдэгтийг удаа дараа том дэвсгэртээр солиулах.

АМЬ НАСНЫ ДААТГАЛ

- Өндөр дүнтэй нэг удаагийн гүйлгээ хийх, мөн төлбөр төлөх,
- Харилцагч нь үр шим хүртэгчийг солих.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Зөвхөн нэг байгууллагын хувьцааг худалдаалах зорилготой данс нээх,
- Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж, арилжаанд оролцох байдлаар санхүүгийн зах зээлд нөлөөлөх хэлбэртэй гүйлгээ хийх,
- Тодорхой шалтгаангүйгээр гуравдагч этгээдээс чек хүсэх гэх мэт хэвийн бус төлбөр тооцоо хийх,
- Брокерийн дансанд хөрөнгө байршуулаад буцаах хүсэлт гаргах,
- Төлбөр гүйцэтгэхээс өмнө өөр хийгдсэн гүйлгээ огт байхгүй эсвэл цөөн байх.

БЭЛЭН МӨНГӨ ЗӨӨВӨРЛӨГЧИД

- МУТСТ тогтолцоо нь сул эсвэл авлигад өртөх өндөр эрсдэлтэй улс руу/аас гүйлгээ хийх,
- Богино хугацаанд бэлэн мөнгөөр тогтмол орлогын гүйлгээ хийх,
- Богино хугацааны дотор хийгдсэн их хэмжээний/ойрхон давтамжтай валютын арилжаа.

ТРАСТ БОЛОН КОМПАНИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

- Эдийн засгийн үндэслэлгүй төвөгтэй бүтэц үүсгэх,
- Шалтгаангүйгээр зуучлагч ашиглах,
- Өндөр эрсдэлтэй улс орноос хөрөнгө хүлээж авах,
- Харилцагч нь нэрлэсэн хувьцаа эзэмшигч эсвэл нэрлэсэн захирлыг ашиглах,
- Харилцагчийн хаяг нь бодитоор байдаггүй бол.

ХАВСРАЛТ 2. ТИПОЛОГИ

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх байгууллагын гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх арга, хэлбэр, схем, аргачлалыг үндэслэсэн болно.⁴

Эдгээр жишээнүүд нь Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (АНДББ)-ын судалгаанаас авсан мөнгө угаах түгээмэл арга, хэлбэр, схемүүд юм.

Авлигатай холбоотой (авлига, авлигаас олсон орлого, МУТСТ арга хэмжээг сулруулдаг авлигын жишээ): УТНБЭ-ийн нөлөөг ашиглан мөнгө угаах үйл ажиллагааг дэмжихийн тулд авлига өгөх: Жишээ нь: мөрдөн шалгалт хийх албан тушаалтан эсвэл банкны комплаенсын ажилтанд авлига өгч мөнгө угаах үйл ажиллагааг явуулсан.

Валютын арилжаа: валют арилжааг ашиглан өөр улс руу мөнгө хууль бусаар хил нэвтрүүлэх эсвэл валют арилжааны үйл ажиллагаанд тавигддаг мэдээлэх шаардлага бага байдгийг ашиглах г.м.

Бэлэн мөнгө зөөвөрлөгч/валют хууль бусаар хил нэвтрүүлэх: Гүйлгээ/Бэлэн мөнгийг мэдээлэх шаардлагаас зайлсхийхийн тулд хөрөнгийг бэлэн мөнгө зөөвөрлөгч ашиглан валют хууль бусаар хил нэвтрүүлэх.

Бага дүнтэй олон гүйлгээ хийх (smurfing): Олон тооны гүйлгээ (орлого, зарлагын гүйлгээ, шилжүүлэг хийх) ашиглах арга, ихэвчлэн янз бүрийн хүмүүс, их хэмжээний жижиг дүнтэй гүйлгээнүүд эсвэл мэдээлэх ёстой босго дүнгээс зайлсхийх зорилгоор олон тооны данс ашиглах.

Кредит карт, чек, өрийн бичиг ашиглах: Ихэвчлэн өөр улсын санхүүгийн байгууллагад хадгалагдаж буй хөрөнгө ашиглах үед хэрэглэгдэнэ.

Зөөвөрлөх боломжтой үнэт эдлэл худалдаж авах (үнэт металл, чулуу): Санхүүгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээнээс зайлсхийх болон мэдэгдэлгүйгээр үнэт эдлэлийг шилжүүлэх/эзэмшигчийг өөрчлөхийн тулд үнэт эдлэл худалдан авах арга техник юм.

Үнэтэй хөрөнгө худалдан авах (үл хөдлөх хөрөнгө, хурдан морь, автомашин): Гэмт хэргээс олсон орлогын эх үүсвэрийг далдлах болон мэдээлэх шаардлагаас зайлсхийхийн тулд өндөр дүнтэй бараа, бүтээгдэхүүнд гэмт хэргээс олсон орлого ашиглах.

Бараа солилцоо (бартер): Санхүүгийн салбарын МУТСТ арга хэмжээнээс зайлсхийхийн тулд санхүүгийн хэрэгсэл эсвэл мөнгө ашиглахаас зайлсхийх – Жишээ нь: алтан гулдмайг героиноор шууд солилцох.

⁴ <http://www.apgml.org/methods-and-trends/page.aspx?p=a4a11dca-75f2-4dae-9c25-6215103e56da>

Цахим шилжүүлэг ашиглах: Хөрөнгө хураагдах эсвэл илрэхээс зайлсхийх зорилгоор санхүүгийн байгууллага эсвэл бусад улс хооронд цахимаар шилжүүлэг хийх.

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ (хавала): Мөнгө шилжүүлэхэд ашигладаг итгэлцлийн сүлжээн дээр үндэслэсэн албан бус механизм. Зарим тохиолдолд банкны салбартай зэрэгцэн ажилладаг бөгөөд зарим улсад хууль бус үйлчилгээнд тооцогддог. Мөнгө угааж байгаа болон терроризмыг санхүүжүүлж байгаа этгээд нь хөрөнгийн эзэмшигчийг нууцлах мөн илрүүлэхээс зайлсхийхийн тулд энэ аргыг ашигладаг.

Худалдаанд суурилсан МУТС үйл ажиллагаа: Ихэвчлэн санхүүгийн ил тод байдлын хууль тогтоомж, зохицуулалтаас зайлсхийх зорилгоор нэхэмжлэл хуурамчаар үйлдэх, худалдааны санхүүжилтийн арга зам эсвэл бараа бүтээгдэхүүн ашиглах.

Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа (казино, морины уралдаан, интернетээр хууль бус мөрийтэй тоглоом тоглох г.м): Санхүүгийн эх үүсвэрийг далдлахад ашигладаг. Жишээлбэл, хууль ёсны тоглогчдоос ялсан билетийг нь худалдаж авах, казиногийн хасааг гэмт хэргийн гүйлгээг хийхэд валют болгон ашиглах, гэмт хэргээс олсон орлогын эр үүсвэрийг далдлахын тулд цахим мөрийтэй тоглоомыг ашиглах.

Ашгийн бус байгууллагыг буруугаар ашиглах: Терроризмын санхүүжилтийг цуглуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг далдлах, терроризмын санхүүжилтийг түгээхэд ашигладаг.

Хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах: Ихэвчлэн мэдээлэх шаардлага дутагдалтай байгааг ашиглан төлбөрийн хэрэгсэл худалдаж авч гэмт хэргээс олсон орлогын эх үүсвэрийг нуун далдалдаг.

Холих (бизнесийн хөрөнгө оруулалт): Мөнгөний эх үүсвэрийг нуун далдлахын тулд гэмт хэргээс олсон орлогыг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлоготой холих үйл ажиллагаа.

Халхавч компани/корпораци ашиглах: Мэдээлэхэд тавигдах шаардлага доогуур байдлыг ашиглан хөрөнгө эзэмшиж буй этгээдийг нуун далдлана.

Оффшор бүсэд байрлах траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг банк/аж ахуйн нэгжийг ашиглах: Хөрөнгө эзэмшиж буй этгээдийг нуун далдлах, дотоодын эрх бүхий байгууллагуудын хяналт/хоригоос зайлсхийнэ.

Итгэмжлэгч, траст, гэр бүлийн гишүүд эсвэл гуравдагч этгээдийг ашиглах: хууль бус хөрөнгө эзэмшиж буй этгээдийг нуун далдлах.

Гаднын банкны дансыг ашиглах: Хууль бус хөрөнгө эзэмшиж буй этгээдийг нуун далдлах, дотоодын эрх бүхий байгууллагуудын хяналт/хоригоос зайлсхийхийн тулд ашиглана.

Биеийн байцаалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх: МУТС үйл ажиллагаанд оролцсон этгээдийг нуун далдлах.

Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийг ашиглах (хуульч, өмгөөлөгч, нягтлан бодогч, брокер г.м): Хууль бус орлогын ашиг хүртэгч болон эх үүсвэрийг нуун далдлах, мөн гэмт этгээдэд мөнгө угаах үйл ажиллагааг санал болгож байгаа хууль бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч.

Төлбөрийн шинэ арга хэрэгсэл ашиглах: МУТС үйл ажиллагаанд шинээр гарч буй арга, техник, хэрэгслийг ашиглах. Жишээ нь: гар утасны технологид суурилсан мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон төлбөрийн систем.